

**ШИНЭ ҮЕЭС ӨМНӨХ ЕВРАЗИЙН УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМ:
ЭЗЭНТ ГҮРЭН БҮРЭЛДЭХ ҮЙЛ ЯВЦ ХИЙГЭЭД
ҮЕ ЗАЛГАМЖЛАН ЗАХИРАХ ТОГТОЛЦОО***

Л. МӨНХ-ЭРДЭНЭ

Удиртгал

Орон нутгийг хамарсан “аймгийн” дэг журмыг халж маш нягт төвлөрсөн эрх мэдэл бүхий төр улсыг буй болгосон тул Чингисийн угсааныхны эрх мэдлийн бүтэц үүсэн байгуулагдсан явдлыг Евразийн улс төр, нийгэм өөрчлөгдөн хувирах үйл явцад гарсан нэн чухал үйл явдал болсныг олон эрдэмтэн хүлээн зөвшөөрдөг. Гэвч зарим эрдэмтэн үүнийг “маш нарийн төвөгтэй чифдом (supercomplex chiefdom)” байсан гэж өнөө хүртэл үзсээр байна.¹ Үнэхээр ч Монголын эзэнт гүрэн мөхөхтэй зэрэгцээд Еврази “аймагт тулгуурласан нийгэм, улс төрийн дэг журам (“tribal”-based social and political order)”-д эргээд задарсан гэж олон судлаач үзжээ.² Чухамдаа энэ парадигмын үүднээс авч үзвэл Шинэ үеэс өмнөх Евразид төвлөрсөн төр улс оршин байсныг тодорхой тайлбарлаж хүчрэхгүй бол түр зуур л оршин тогтнодог гэх юм уу, тэр төр улс байнга ноёрхохгүй бол “аймгийн” дэг журам эргээд давамгайлдаг гэж үздэг.

Гэхдээ Дэвид Снит эл парадигмыг “XIX зууны европ төвт үзэл бүхий хувьслын онолд тулгуурласан, колоничлолын үеийн буруу ухагдахуун” гэж үзэж татгалзаж ийнхүү бичжээ:

Дотоод Азид эрх мэдлийн маш олон хэлбэр төр улсын шинжтэй байсан бөгөөд бодит байдал дээр тэдгээр нь улс төрийн төвлөрлийн хувьд бүгдийг ноёрхсон байх хэр хэмжээнээс тусгаар, бие даан оршиж байсан гэж болно... Эртнээс нааш Дотоод Азийн төр улс буй болоход нөлөөлдөг орон нутгийн эрх мэдлийн харилцаа нь бүгдэд ноёрхлоо тулган хүлээлгэсэн буюу төв “тэргүүн”-тэй байсан ч, байгаагүй ч явагддаг... Язгууртнуудын улс төрийн харилцаа нь улс төрийн эрх мэдлийг

* Journal of the Royal Asiatic Society Third Series, Vol. 26, No. 4 (October 2016), pp. 633-655

¹ N. Krardin and T. Skrynnikova, “Stateless head: notes on revisionism in the studies of nomadic societies”, *Ab Imperio*, IV (2009), pp. 117-128.

² Жишээ нь, Т. J. Barfield, *The Perilous Frontier: Nomadic Empires and China, 221 bc to ad 1757*, (Oxford, 1989), I. Togan, *Flexibility and Limitation in Steppe Formations: The Kerait Khanate and Chinggis Khan* (Leiden, 1998) бүтээлийг үзнэ үү.

төвлөрүүлэх хэмжээ, цар хүрээ, зэргийг тодорхойлж ирсэн... Тийнхүү төвлөрсөн “төр улс” нэгэн төрлийн язгууртны засаглал болж байгуулагддаг байна.³

Снит цааш “давхраажилт, төр улсын харилцаа нь хүнд суртлын төвлөрсөн бүтцээс хамаардаггүй болохыг мэдэх нь олон давхарга бүхий эрх мэдлийг, тэдгээрийн үндэс сууринд оршиж буй язгууртны дэг журмыг улам хялбар ялгахад тусалдаг” гэж бичжээ.⁴ Тэгэхээр шинэ үеэс өмнөх Дотоод Азийн нийгмүүд нь аймгийн бус, харин язгууртны шинжтэй байсан, тиймээс тэрхүү “төр улсууд” нь уг чанараараа төвлөрсөн, эсвэл төвлөрсөн нь задарсан, эсвэл бүр “тэргүүнгүй” төр улс байсан эсэхээс үл хамааран язгууртны улс төрийн бүтэцтэй байжээ гэж Снит үзэж буй аж. Энэ нь олон эрдэмтний төр улс юм уу, төвлөрсөн төр улс гэж үзэж буйг Снит “язгууртны засаглалын нэг хувилбар”, өөрөөр хэлбэл язгууртны, магадгүй төвлөрсөн төр гэж үзэж байгаа хэрэг. Хэдийгээр Снит язгууртны дэг журам гэж нэрлэж буй зүйлийнхээ уг гарал, мөн чанар, хувирал өөрчлөлтийн талаар цааш гүнзгийрүүлэн тэр бүр судлаагүй ч төсөөлж боловсруулж бичсэнээс нь язгууртны засаглал нь ямагт оршиж байсан, тэр язгууртны засаглал нь юу юунаас илүү төвлөрсөн төр улсыг бүтээдэг байжээ гэсэн сэтгэгдэл төрж байгаа юм.

Хэдий тийм ч “дундад зууны Евразийн нүүдэлчин аймаг нь түүний тэргүүнээр тодорсон хүнд захирагдахыг, мөн аймгийнхантайгаа ашиг сонирхол нэгтэй байхыг хүссэн хэн бүгдэд нээлттэй байдаг улс төрийн организм байсан” болохыг нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн цөөнгүй судлаач судалгаагаараа нотолдог.⁵ Дундад зууны үеийн Монголыг судалсан эрдэмтэд ч голдуу ингэж үзэж байсан бөгөөд тухайлбал Томас Олсен ийнхүү бичжээ:

Гарал үүслийн талаас аваад үзсэн ч угсаа залгамж хийгээд аймаг нь үнэн хэрэгтээ бодит гэхээсээ зохиомол цусан төрлийн холбоогоор холбогдсон хүмүүсээс бүрдсэн улс төрийн байгуулал байжээ. Тал нутагт, улс төрийн нийтлэг ашиг сонирхол нь үндсэндээ ураг төрлийн холбоотой адилхан ойлгогддог аж. Тиймээс дундад зууны монголчуудын (мөн бусад овог аймгийн) уг гарлыг бичсэн бичмэл нь улс төрийн байгууллыг нь баталгаажуулахад зориулагдан зохиогдсон үзэл суртлын шинжтэй бичмэлүүд байсан юм. Иймд тэдгээр нь биологийн харилцааг илтгэн харуулсан нотолгоо болж чадахгүй.⁶

³ D. Sneath, *The Headless State: Aristocratic Orders, Kinship Society, and the Misrepresentations of Nomadic Inner Asia* (New York, 2007). pp. 1–5.

⁴ Мөн тэнд, р. 197.

⁵ R. P. Lindner, “What was a nomadic tribe?”, *Comparative Studies in Society and History*, XXIV, 4 (1982) pp. 689–711. Руди Линднер бээр Мортон Фридийн “хоёрдогч аймаг” гэсэн ухагдахууныг өргөтгөн “нүүдэлчдийн” ертөнцийн хувьд хэрэглэж улам дэлгэрэнгүй боловсруулсан байдаг. Гэтэл үнэн хэрэгтээ Фрид өөрөө “хоёрдогч аймгууд” гэгчээ Хүннүгээс Чин гүрэн хүртэлх нэн удааны хугацаанд оршин байсан Евразийн нүүдэлчдийн дундаас “олсон” байх юм. M. Fried, *The Notion of Tribe*. (Menlo Park, 1975). p. 72-оос үзнэ үү.

⁶ T. Allsen, “The Rise of the Mongolian Empire and Mongolian Rule in North China” in *The Cambridge History of China: Alien Regimes and Border States 907–1368*, VI, (ed.) H. Franke and D. Twitchett (Cambridge, 1994), pp. 321–413.

Үүнтэй адил, Питер Голден ч бас “Евразийн нүүдэлчдийн тухай судалсан олон судалгааны дийлэнх нь “аймаг, “овог” хоёрыг байнга тогтворгүй шинжтэй, өөр хоорондоо адилгүй элемент бүхий улс төрийн нэгдэлтэй холбогдсон нарийн төвөгтэй үзэгдэл байсан гэж үзсээр иржээ” хэмээн дэмжиж бичсэн байдаг⁷ бол Томас Барфилд үүнийг баталж ингэж бичсэн байх аж:

Угсаа гарлын хувьд конус хэлбэрийн овгийн загвартай хэмээн антропологичид үзсээр ирсэн гэж Снит нотлох гээд байгаагийн эсрэгээр харин ч нийтэд их дэлгэрсэн үзэл байдаг нь Дотоод Азийн тийм аймгийн холбоонууд нь доороос дээш байгуулагдсан холбоо эвсэл бус, харин дээрээс доош хуваагдсан задралаас үүдэн ахин зохион байгуулалтад орсон холбоо байсан гэсэн үзэл юм. Тэгэхээр ураг төрлийн харилцаа нь харьцангуй жижиг нэгж болох нуклеар гэр бүл, өргөн өрхийн дотор голдуу их тодорхой “бодитой” оршин байсан гэж эртнээс үзсээр ирсэн байдаг.⁸

Гэсэн ч “ураг төрөл... овог, аймаг... болбоос хожим нь тэлж өргөссөөр явцуу утгаараа ураг төрөлд үндэслэсэн улс төрийн бүтэц байхаа больдог элемент байсан” гэж Голден үзээд “Снитийн дэвшүүлсэн зүйл нь Чингисийн угсааныхны хожуу үеийн Монгол (мөн бусад аймгуудын) ертөнцийг судлахад илүү тохиромжтой санал байж болох юм” гэжээ.⁹ Гэхдээ тэр бээр үүнийг “Чингисийн угсааныхнаас өмнө оршиж байсан тал нутгийн улс төрийн нэгдлүүдийг судлахад хэрэгтэй хэрэгсэл гэж үзээгүй” ажээ.¹⁰ Түүнтэй адилаар Барфилд Снитийн загварыг Чингийн өмнөх цаг үед хэрэглэхэд “асуудалтай” гэж үзэхээр барахгүй мөн ийм “шатлан захирах ёс нь” Дотоод Азийн гадна оршин байсан “бэлчээрийн нүүдлийн аж ахуйт нийгмүүдэд маш сул юм уу, огт байгаагүй” гэжээ.¹¹ Тэгэхээр аймгийн дэг журам нь Евразид л, түүнд салшгүй юм уу, нэн чухлаар оршин байсан бол төр улсын хувьд огт тийм байгаагүй гэж Барфилд төсөөлж байгаа юм.¹² Тиймээс Барфилд “аймгийн зохион байгуулалт орон нутгийн түвшинд хэзээ ч алга болдоггүй” хэмээн эрс шийдэмгий бичсэн байна.¹³

Үнэхээр ч “аймгийн парадигм” гэх ухагдахууныг хэрэглэж буй эрдэмтэд “аймаг”-ийг шинэ үеэс өмнө оршиж байсан нүүдэлчдэд салшгүй байсан юм уу, зайлшгүй оршин байсан улс төрийн зохион байгуулалт” гэж үзэж байгаа бол олон эрдэмтэн “аймаг”-ийг ураг төрлийн өргөтгөсөн байгуулал төдий үзсээр байна. Тэдний хувьд “аймаг” гэгч өндөр түвшний ураг төрлийн нэгтгэл болох ч зохиомол олон элемент агуулсан маш нарийн төвөгтэй, хийсвэр ойлголт болдог.¹⁴

⁷ P. Golden, “A review of *The Headless State: Aristocratic Orders, Kinship Society, and Misrepresentations of Nomadic Inner Asia* by David Sneath”, *Journal of Asian Studies* LXVIII (2009), pp. 293–296.

⁸ T. J. Barfield, 2009. “A review of *The Headless State: Aristocratic Orders, Kinship Society, and Misrepresentations of Nomadic Inner Asia* by David Sneath”, *Comparative Studies in Society and History*, LI, 4, pp. 942–943.

⁹ Golden, “A review of *The Headless State*.” p. 296.

¹⁰ Мөн тэнд

¹¹ Barfield, “A review of *The Headless State*.” p. 943.

¹² Barfield, *The Perilous Frontier*. pp. 24–28.

¹³ Мөн тэнд, p. 8.

¹⁴ Жишээ нь, мөн тэнд, pp. 26–27, мөн T. Allsen, “The Rise of the Mongolian Empire”, p. 321-ийг үзнэ үү.

Тиймээс “аймгууд”-ын үүсэл юм уу, уг гарлыг авч үзэх шаардлага ч байсангүй. Тэдний хувьд “аймгууд” нь нүүдэлчин Евразийн нийгэм-улс төрийн гол нэгж болж байв. Тиймээс, шинэ үеэс өмнө оршин байсан Евразийн улс төрийн бүтцийг аймгийн төр улсын бус бүтэц ба язгууртны төр улсын бүтэц гэсэн хоёр ялгаатай байдлаар тайлбарлаж байна.

Энэ өгүүлэлдээ би өгүүлэн буй категориуд, өөрөөр хэлбэл “аймаг”, Голдений томьёолсноор “язгууртны засаглалаар удирдуулсан бүлгүүд”-ийн үүсэл, уг гарлыг авч үзэж шинэ үеэс өмнө оршин байсан Евразийн улс төрийн дэг журам нь үнэхээр аймгийн юм уу, язгууртны шинж чанартай байсан эсэхийг нягтлахыг зорив.¹⁵ Иймээс дараах асуудлуудыг дэвшүүлж байна: Эдгээр категори хаанаас буй болсон, хэрхэн бүрэлдэн тогтов? Цаашилбал, улс төрийн дэг журам гэсэн утгаар авч үзвэл Чингисийн угсааны өмнөх Монгол Чингийн өмнөх Монголынхоос яг хэрхэн ялгагдаж байсан бэ? “Аймгийн”, “язгууртны” үүсэл, уг гарлын талаар ийм асуулт тавьснаар маргаан мэтгэлцээн өрнүүлэх нь гарцаагүй, мөн үүнд үндэслэлтэй хариулт өгөх нь ч асар бэрхшээлтэй, гэвч мэдээжийн хэрэг тийм ч боломжгүй зүйл ч бас биш юм. Түүнчлэн, дээрх асуултад Ляо улс, Чингисийн угсааны улс, Чин гүрний үед Дотоод Азийг нэгтгэсэн үйл явцуудыг харьцуулах замаар хариулт өгөх нь үлэмж эргэлзээ төрүүлж болно.¹⁶ Тиймээс миний доор өгүүлэх зүйлс нийтийн үздэгээс нэлээд өвөрмөц, маргаан мэтгэлцээн өрнүүлж болохын сацуу таамаглах, бодож боловсруулах шатанд яваа зүйл гэдгийг урьдаас анхааруулж хэлэх нь зүйтэй. Харин миний задлан шинжилсэн зүйл Хүннүгээс өмнөх Дотоод Азийг ойлгоход онцын хэрэг болохгүй болов уу. Гэхдээ Хүннүгээс хойших Дотоод Азийг шинжлэхэд хэрэглэж болохын зэрэгцээ Чингисийн угсааны Евразийг судлахад бүр ч тохиромжтой гэж бодогдоно. Миний дэвшүүлж буй зүйл түүхэн хэрэг бүрийг тайлбарлахад чиглээгүй, гэхдээ Хүннүгийн дараах Евразийг судлахад тааралдах олон түүхэн тохиолдлыг тайлбарлах боломж өгч байгаа гэж бодож байна.

Ингэхдээ би юуны түрүүнд Чин гүрнээс Монголыг нэгтгэсэн үйл явцыг задлан шинжилж уг үйл явц Монголыг бүхэлд нь, ялангуяа Монголд өмнө нь байсан *түмэн*, *отгийг* хэрхэн өөрчлөн хувиргасныг авч үзнэ. Чин гүрэн эдгээр улс төрийн бүтцийг устгаж дүр эсгэсэн буюу улс төрийн бус, дэд төр улсын (дэд-эзэнт гүрний) түвшний ач холбогдол бүхий категори болгон хувиргасан билээ. Мөн Чин гүрэн Монголыг нэгтгэсний дараа дүр эсгэсэн-улс төрийн хүн амын категори, дэд төр буюу засаг захиргааны “доршоосон” ойлголт ухагдахуун, нэр нэршлийг хэрхэн буй болгосныг харуулна. Эцэст нь, “цэргийн тоогоор үе залгамжлан захирах тогтолцоо” хэмээн миний нэрлэж буй ухагдахууны мөн чанарыг задлан шинжилж, мөн энэ нь “аймгийн” буюу “язгууртны дэг журам”-ууд үүсэн буй болоход ямар учир холбогдолтой байсныг товч өгүүлэх болно.

¹⁵ Golden, “A review of The Headless State.” p. 295.

¹⁶ Харьцууллыг бүтцийн түвшний хувьд л хийх бөгөөд зөвхөн “аймаг”, “язгууртан”, эсвэл *мянган* буюу *хошууны* түвшний бүтцийн тухайд авч үзэхийг онцлон тэмдэглэмээр байна.

Эзэнт гүрнүүдийн бүрэлдсэн үйл явцыг харьцуулах нь

Энэ хэсэгт би Ляо улс, Чингисийн угсааны улс, Чин улс гэсэн гурван улс Дотоод Азийг нэгтгэсэн үйл явцыг харьцуулсны үндсэн дээр эдгээр гурван улсын төрөөс Дотоод Азийг нэгтгэхийн тулд хэрхэн цэргийн тоогоор зохион байгуулагдаж үе улиран захирах нэгж байгуулсныг харуулахыг зорилоо. Ингэхдээ Чин гүрнээс Монголыг нэгтгэсэн үйл явцаас эхэлж Чингисийн угсааныхны болон Ляо улсынх руу шилжиж, үе залгамжлан захирах тогтолцоо болон улс төрийн дэг журам хэрхэн үүсэж, хувирч, үргэлжилж байсныг онцлон шинжлэх болно.

Чин гүрэн Монголыг нэгтгэсэн нь: Хошуу, Аймгийг буй болгосон нь

XIX зууны дунд үе гэхэд европ эрдэмтэд монголчуудыг Цахар, Халх, Хорчин зэрэг олон “аймгууд”-аас бүрдсэн “арьстан” юм уу, “үндэстэн” болохыг мэдэх болсон байв. Тиймээс тухайлбал Роберт Лейтем 1859 онд бичсэн *Дескриптив Этнологи* хэмээх бүтээлдээ¹⁷ олон монгол “аймгууд”-ын тухай дэлгэрэнгүй бичиж, чингэхдээ ийн өгүүлжээ:

Арабыг эс тооцвол дэлхийн аль ч хэсэгт Монгол шиг аймгийн тогтолцоо хөгжсөн газар үгүй. Энд нэгэн аймгийн гишүүд, элэнц хуланц, үр хойчис хоорондоо цусан холбоотой байдаг. Зарим тохиолдолд аймаг нь жинхэнэ, зөвшөөрөгдсөн эцэг өвгөөрөө нэрлэгдсэн байдаг.¹⁸ Тэдний төрөлх хэлээр *aimauk*, *aimak* гэснийг бид “tribe” гэж орчуулж буй энэ ойлголт нь засаг захиргааны том нэгж бөгөөд дотроо олон *kokhum* [*khoshuu*] буюу хошуунд хуваагдана.¹⁹

Тэгэхээр Шинэ үеэс өмнөх Монгол ямагт олон тооны “аймаг”-аас бүрдэж байжээ гэсэн үзэл Шинэ үеэс өмнөх Монголыг ойлгон ухаарах гол парадигм болон тогтсон агаад энэ парадигм гарснаасаа хойш өнөө хүртэл давамгайлсаар байна. Аймгаар зохион байгуулагдах үзэгдлийг уйгагүй ил тод шүүмжилж байсан Мортон Фрид өөрөө “хоёрдогч түвшний аймгаар зохион байгуулагдах үзэгдэл” Евразийн Хүннү, Түрэг, Монгол, Манжийн эзэнт гүрний хувьд “нүсэр том хоёрдогч түвшний төр улс байгуулагдан хөгжих урьдчилсан нөхцөл болдог” гэдгийг хүлээн зөвшөөрч байв.²⁰

Үнэхээр ч Чин гүрний эрхшээлд бүх монголчууд 200 орчим *хошуунд* (*khoshuu*) хуваагдаж байсан билээ. Чингийн үед “Гадаад Монгол”-ын (*gadagadu*

¹⁷ Лейтем *Монголчууд*-ын тухай дэлгэрэнгүй бүлэг бичээд түүндээ Жюлиус Клапроф (1783-1835), Исаак Якоб Шмидт (1779-1847) зэрэг тухайн үеийн нөлөө бүхий дорно дахин судлаачдын бүтээлийг эшилжээ. Мөн тэр бээр Егор Тимковскийн (1790-1875) нэртэй бүтээлийн англи орчуулгыг үлэмж ашигласан байдаг. R. Latham, *Descriptive Ethnology: Eastern and Northern Asia-Europe*, Volume 1, (London, 1859). pp. 289–340-ийг үзнэ үү.

¹⁸ Лейтем Рашид ал-Дин бичсэнийг давтсан юм. “Аймаг, угсаагаа мэддэггүй хүн тэдний дотор нэгээхэн бээр үгүй. Арабуудыг эс тооцвол монголчуудаас өөр ямар ч үндэстэнд угсаа гарлаа бичиж хадгалах ийм ёс заншил байдаггүй” гэж Рашид ал-Дин бичсэн байдаг. Rashiduddin Fazlullah, *Jami' u't-tawarikh: Compendium of Chronicles, A history of the Mongols*. Part I. Trans. W. M. Thackston, (Cambridge, MA, 1998). p. 116-г үзнэ үү.

¹⁹ Latham, *Descriptive Ethnology*, p. 290.

²⁰ Fried, *The Notion of Tribe*. p. 72.

mongqol)²¹ хошууд цөм монгол засаг тайж нарын өв залгамжлан захирдаг эзэмшил нутаг болж байсан бол “Гадаад Монгол”-д хамаардаггүй Цахар зэрэг зарим монгол хошууг Чингийн төрөөс тусгайлан томилсон түшмэд буюу бүгдийн дарга нарт захируулж байв. Гадаад Монголын ихэнх хошууг хамруулж чуулгануудыг (*chuulgan*) бүрдүүлдэг байсан ч чуулганд хамаарагддаггүй олон хошуу байв. Харин чуулган даргын газар нь Чингийн төрөөс хэд хэдэн хошууны засаг ноёныг томилон зохион байгуулдаг хурал байв. Чуулган даргын газар тухайлан тогтсон байршилд гурван жил тутам нэг удаа чуулдаг байжээ.

Үүний сацуу Монгол бараг 40 аймагт (*ayimaq*) хуваагдаж байв. Тэдгээр аймгийн дийлэнх нь өвөрмөц нэршилтэй байхад зургаа нь нийтлэг нэг нэрээр нэрлэгддэг байжээ.²² Бүх аймаг нарийн тогтоосон газар нутагтай бөгөөд дөрвийг нь хан удирдаж, ханы цолоор аймаг нэрлэгдэж байв. Нэг хошууг хэд хэдэн аймагтай хамт чуулганд хамааруулан байгуулж байхад хоёр болон түүнээс дээш хошууг хамааруулан байгуулж байсан явдал ч бий. Гэтэл томоохон аймгууд 20 гаруй хошуунд хуваагдаж байсан хэр нь давхар чуулганд хамаарагдах нь байсан. Хэрвээ хошуу, чуулганыг Чингийн засаг захиргааны бүтцэд хамааруулан авч үзэх бол аймаг нь чухам юу байсан нь тодорхойгүй үлдэж байна. Тэгвэл урьд аймаг (“tribe”) гэгдэж байсан энэ зүйл чухам юу байв?

Тэдгээр аймгийн нэрийн ихэнх нь XIII-XIV зууны сурвалжуудад гардаггүй. Харин Мин улсын үеийн сурвалж бичгүүдэд анх тохиолдоно.²³ XVI зууны сүүл,

²¹ *Gadagadu (tulergi, wai), dotogadu (dorgi, nei)* гэсэн хоёр нэр томьёог хэрхэн ингэж нэршиж хэвшсэн байдал тодорхойгүй. Энэ нь манж, монгол хоёр үндэстний харилцааны мөн чанарыг эсрэгүүлж байгаа төдийгүй судлаачдад төөрөгдөл үүсгэж байдаг. Өвөр Халх (түүний зарим хэсэг), мөн Монголын зарим бага ноёд харьяат иргэдийн хамт манжуудад дагаар орох үед нь манж найман хошуунд нэгтгэж Манжийн төрийн харьяат иргэд болгосон. Тиймээс тэднийг “дотоод (*dotagadu, dorgi, nei*)” монголчууд хэмээн нэрлэж, ямагт манжууд болон Тэнгэрийн цэрэгтэй хамт дансалж бичиж иржээ. Тухайлбал, *Mongqol dangsa ebhemel-ün emhithel*, III (Öbür Mongqol-un arad-un heblel-ün horigi-a, 2003) p. 215-ийг үзнэ үү. Манжууд “дотоод монголчууд” гэдгийн эсрэгээр хорчин, харчин зэрэг бусад бүх монголчуудыг “гадаад (*tulergi*) монголчууд” хэмээн нэрлэж байв. M. Weiers, “Die Historische Dimension Des Jade-Siegels Zur Zeit Des Mandschuherrschers Hongtaiji”, *Zentral-Asiatische Studien*, XXIV (1994), pp. 119–145-ыг үзнэ үү. Гэтэл Манж улс эдгээр дотоод монголчууд тус бүртэй харилцахдаа Хорчин улс, Харчин улс гэх мэтчилэнгээр, тиймээс Манж улстай адил байр суурьтай мэт харьцаж нэрлэдэг байв. Тэгэхээр “дотоод” гэдэг үг Манжийн төрд үйлчилсэн, дагаар орсон харилцааг заадаг бол “гадаад” гэдэг нь эсрэг утга зааж байх ёстой болно. Харин үнэн хэрэгтээ “гадаад монголчууд” буюу Хорчин, Харчин зэрэг монгол улсууд Манж улстай эвсэл холбоо байгуулсан монголчууд байв. Гэхдээ тэд ч бас Манжийн төрд дагаар орогсод мөн билээ. L. Munkh-Erdene, “The 1640 Great Code: an Inner Asian parallel to the Treaty of Westphalia”, *Central Asian Survey*, XXIX, 3 (2010) pp. 269–288, L. Munkh-Erdene, “The Qing transformation of Mongolia: structural ethnicization and tribalization”, International workshop “Administrative and Colonial Practices in Qing Ruled China: Lifanyuan and Libu Revisited”, Max Planck Institute for Social Anthropology, Halle, 7–8 April, 2011-д тавьсан илтгэлийг үзнэ үү. Тэгэхээр тухайн үед “Гадаад Монгол улс” хэмээх үгийг хэрэглэж буй захидал манж нэр томьёог авч ашиглаж байгаа төдийгүй тэдгээр улсын Манжийн төрийн гадна буй байр суурьтай гэсэн утга зааж байгаа юм. Харин XIX зууны төгсгөл гэхэд Гадаад Монгол гэдэгт барагцаагаар Өвөр, Ар аль аль Монгол хамрах болсон байв.

²² *Илтгэл уацур-т* Халхын зургаан аймаг гэжээ. *Zarlgaar togtooson Mongol, Khoton aimgiin wan güngüüdin ileterg shastir*, (ed.) A. Ochir, Vol.1 (Ulaanbaatar, 2007)-г үзнэ үү.

²³ H. Serruys, *Sino-Mongol Relations during the Ming II, The Tribute System and Diplomatic Missions (1400-1600)*, (Brussels, 1967), D. Pokotilov, *History of the Eastern Mongols during the Ming Dynasty*

XVII зууны эхэн үеийн монгол сурвалжуудад тэдгээрийн нэр *түмэн* (*tümen*), мөн *отог* (*otoq*) юм уу, *хошуу* болж гардаг. Тэдгээр сурвалжийн мэдээгээр Чин гүрэн байгуулагдахаас өмнө Монгол *түмэн*, *отгоос* (Халх, Алтан ханы цаазад *хошуу*) бүрдэж байв.²⁴ *Түмэн*, *отог* хоёр нь Монголын засаг захиргааны шат дараалсан нэгж болж байжээ. Өөрөөр хэлбэл, Монгол *түмэнд* хуваагдаж, *түмэн* нь *отгуудад* (буюу *хошуунд*) хуваагдаж байв. Харин Чин гүрэн монголчуудыг нэгтгэж эхлэх үед зүүн Монгол зургаан *түмэн*, тэдгээр нь 54 *отгоос*, баруун Монгол нь дөрвөн *түмэн*, олон тооны *отгоос* бүрдэх болжээ.²⁵ Бүх *түмэн*, *отог* өөрийн гэсэн нэр, тогтсон газар нутаг, засаг ноён, олон тооны түшмэд, засаг захиргааны нийтлэг байгуулал, цаазтай байв. Гэвч Даян хааны үр хөвүүд *түмэн*, *отгуудыг* аппанаж буюу *хувь* (*qubi*) болгон хувааж авсан учир тэдгээр нь аяндаа түүний удмынхны эзэмшил болон хувирсан ажээ.²⁶ Тийнхүү XVII зууны эхэн үе гэхэд монголчуудын төрийн бүрэн эрх нь олон хэсэгт бутарч, төвлөрсөн улс төрийн эрх мэдэл нь сарнин задарчээ. Өөрөөр хэлбэл, Их хааны бүрэн эрх нэр төдий үлдэж, хан, хунтайж, орон нутгийн засаг ноёд өөр өөрсдийн багахан эзэмшил нутагтаа жинхэнэ ёсоор удирдагч болон хувирсан байна. Энэ үйл явц Ариун Ромын эзэнт гүрний бутарч, задарсан үйл явцтай адил төстэй болж өрнөсөн юм.²⁷

Тиймээс XVII зууны эхэн гэхэд зарим *түмнийг* монгол он дарааллын бичгүүдэд *улс* хэмээн дурдах болжээ.²⁸ *Улс* хэмээх нэр томъёо нь хан хөвүүдийн янз бүрийн хэмжээтэй эзэмшил нутгийг хэлэх бөгөөд төр буюу засаг барих зорилгоор байгуулагдсан улс төрийн нэгдэл гэсэн утгатай гэж ойлгох нь зүйтэй.²⁹ Манж-Монголын харилцааг тодорхой өгүүлсэн бичиг баримт, Чингийн эхэн үеийн баримтуудад бүх түмэн, зарим отгийг улс төрийн тодорхой түвшний бие даасан байдалтай байсныг илтгэн монголоор *улс* (*ulus*), манжаар *гүрүн* хэмээн нэрлэсэн байдаг. Харин Чин гүрэн байгуулагдахтай зэрэгцээд тэд бүгдийг *аймаг* гэж нэрлэх болсон байна.³⁰ Кристофер Атвудын нотолсноор Чин гүрэн Монголыг эрхшээх хүртэл монголчуудын засаг захиргааны нэгж буюу категори болгож *аймаг* гэх үгийг хэзээ ч хэрэглэж байгаагүй.³¹ Харин үүнийг голдуу сүсэг бишрэл/шашны, мөн түр зуурын зорилгоор байгуулагдсан нэгжийг нэрлэхэд хэрэглэж

from 1368 to 1634, translated by Rudolf Loewenthal (Arlington, VA, 1976)-г үзнэ үү.

²⁴ Munkh-Erdene, “The 1640 Great Code”.

²⁵ C. Atwood, “Banner Otog, thousand: appanage communities as the basic unit of traditional Mongolian society”, *Mongolian Studies*, XXXIV (2012), pp. 1–76, C. Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire* (New York, 2004.), pp. 430–431, 505-ыг үзнэ үү.

²⁶ Munkh-Erdene, “The 1640 Great Code”.

²⁷ Мөн тэнд

²⁸ J. Elverskog, *The Jewel Translucent Sutra: Altan Khan and the Mongols in the Sixteenth Century* (Leiden, 2003), pp. 242, 253, 277, 278.

²⁹ L. Munkh-Erdene, “Where did the Mongol Empire come from? Medieval Mongol ideas of people, state and empire”, *Inner Asia*, XIII, 2, (2011) pp. 211–237.

³⁰ Munkh-Erdene, “The Qing transformation of Mongolia”.

³¹ C. Atwood, “How the Mongols got a word for tribe—and what it means”, *Studia Historica Mongolica*, Tomus X (2010) pp. 63–89.

байжээ. Тэгвэл тэдгээр урьдын *түмэн*, *отог* хэрхэн *аймаг* гэгдэх болов? Ямар учраас *аймаг* болгов? Ер нь *аймаг* гэгч юу байв?

Лигдэнг насан эцэслэхээс өмнө манж хаад Монголын ихэнх *түмэн*, олон *отгийг улс* болохыг хүлээн зөвшөөрч байсныг сурвалж бичиг нотолно. Чингэж *түмэнг улс* болохыг хүлээн зөвшөөрсөн нь Монголын Их хаанаас тусгаар байлгах гэсэн зорилготой байв.³² Манжууд яваандаа монгол Их хааныг устган Монголыг бутаргаад харьяандаа оруулах болов. Харин Лигдэнг насан эцэслэсний дараа хоосон үлдсэн их хааны суудлыг олж авахын тулд Хунтайж монгол холбоотнуудаа өөртөө нэгтгэхээр ятгаж чаджээ. Хунтайж болон түүний холбоотон монгол язгууртнууд нийт монголчуудаа нэгэн тугийн дор нэгтгэхийн тулд шинээр буй болсон *улсуудыг* (өөртөө засах боломжтой хан хөвүүдийн эзэмшил) буцаан нэгтгэх шаардлагатай болсон юм.³³ Ингэхдээ Хунтайж, монгол язгууртнууд монголчуудад өмнө хэрэглэгдэж байсан улс төрийн зэрэг дэв, нэгдэл сэргэхээс сэргийлж тэдгээр шинээр гарч ирсэн *улсыг* манжуудын идэвхтэй хэрэглэх болсон, бас манж үгтэй ч (*aiman*) үндэс нэг *аймаг* хэмээх нэр томъёог ашиглан нэрлэх болжээ. Энэ нь өмнөх *түмэн*, *отгийн зэргийг* халж эрх мэдэл тэнцүү байлгах гэсэн санаа байлаа. Гэвч Чингийн төр өөртөө *түмэн-улс-аймгуудыг* нэгтгэхдээ *gadagadu muji (external vassal domains)*, *gadagadu ayimaq (external division)*, *tulergi golo (external province)*, эсвэл *wai-fan (external fiefdom)* хэмээн нэрлэх болсон билээ. Эдгээрээс яваандаа манжийн *tulergi golo* гэх ойлголтыг голчлон илэрхийлэх *Гадаад Монгол* гэсэн нэр томъёо үүсэж, харин *аймаг* нь түүний доторх засаг захиргааны нэгжийг заах нэр томъёо болон хувирчээ.³⁴ Тиймээс Монголын тусгаар тогтносон улс төрийн нэгдлийг бутаргаж Чин гүрний вассал хангуудын эзэмшил болгон нэгтгэсэн явдлаас үүдэн *түмэн*, *отгууд* нь *аймаг* болон хувирсан гэж үзэж болно.

Тэгвэл *аймаг* нь чухам юу вэ? *Аймаг* нь Чин гүрний зах хязгаар нутаг болсон Гадаад Монголын засаг захиргааны нэгж байсан нь тодорхой.³⁵ Чин гүрний вассал хан хөвүүдийн эзэмшил болно гэдэг нь Чин гүрний засаг захиргааны дэд нэгж болно гэсэн үг байв. Тэгэхээр *аймаг* нь манжийн төрийн нэгжид захирагдах доод нэгж болжээ. Гэхдээ “гадаад вассал эзэмшил” болохынхоо хувьд *аймгууд* тодорхой хэмжээгээр өөртөө хэрэг мэдэж шийдэх, өөртөө засаглах, тодорхой нэртэй байх, “газар нутгаа бүрэн бүтэн хадгалах”, мөн *чуулган* байгуулж хуралдуулах, манжийн хааны ордонд байр суурь эзлэх зэрэг онцгой эрх ямба эдэлж байв. Гэвч монгол язгууртнуудын итгэлийг олж авахын хажуугаар *түмэн-улс-аймаг* гэсэн том бүтцийн хүч чадлыг бутаргахын тулд Хунтайж болон түүний дараа ор эзэлсэн Чин гүрний эзэн хаадын аль аль нь бага буурай монгол

³² Munkh-Erdene, “The 1640 Great Code”.

³³ *Dayiching ulus-un magad hauli* (Qing veritable records), II (Öbür Mongqol-un soyol-un heblel-ün horyi-a, Nayilar hota, 1990), p. 772-ыг үзнэ үү.

³⁴ Munkh-Erdene, “The Qing transformation of Mongolia”.

³⁵ Гадаад Монгол, гадаад аймаг буюу муж, түлэрг голо, вай-фань зэрэг нэр томъёо нь Монголыг буюу монгол улсуудыг бие даасан, өөрийн хэргийг шийддэг байсан байр байдлаас нь салгаж Чин гүрэн, түүний эзэн хаанаас хамаарсан, харьяанд нь захирагдсан, засаг захиргааны нэгж нь болсон, зах хязгаарын, дорд байр сууринд аваачсан хэрэг болсон юм.

ноёд, тайж нарын хамжлага ардаа, газар нутгаа өв залгамжлан захирах эрхийг хүлээн зөвшөөрсөн юм. Өөрөөр хэлбэл, энэ нь тэднийг өв залгамжлан захирагч *засаг* ноёд мөн болохыг хүлээн зөвшөөрсөн төдийгүй эзэмшил нутгуудыг нь *хошуу* болгон байгуулсан хэрэг болно. Ингээд том *аймгуудыг* цөмийг нь олон жижиг *хошуудад* хуваасаар үлэмж давамгайл хүч чадалтай хантай байх нэг ч том *аймаг* үлдээсэнгүй. Харин оронд нь хошуу бүрийг харилцан бие биеэс хамааралгүй байхаар бие даасан эрхтэй эзэмшил болгов. Ингэснээр аймгуудын хуучин удирдагчид бүгд цол, хэргэм зэрэг, цалин пүнлүү олж авч, тэр бүү хэл зарим нь хан цолоо хадгалан үлдсэн ч бодит байдал дээр тэдний хүч чадал, эрх мэдэл өөрсдийнх нь харьяаны олон жижиг *хошуудаар* хязгаарлагдан багассан юм. Тиймээс том *аймгуудад хошууны* түвшнээс дээш гарах нэг ч бодит нэгдэл, удирдлага байхааргүй болжээ. Ийнхүү *түмэн-улс-аймгийг* бутарган жижиглэх явдал амжилттай хэрэгжив. Үүнд эдгээр засаг захиргааны нэгжүүдээс урьдын *түмэн* хамгийн том нь болсон. Гэхдээ дан *хошуудаас* бүрдсэн жижиг *аймгууд* Чингийн төрөөс *хошууны* хэлбэрээр шинээр байгуулсан цорын ганц улс төр-засаг захиргааны нэгж болон үлджээ. Гэтэл том *аймгууд* нь тэргүүнгүй эзэмшил (headless realm) болон хувирсан байна.

Үүний сацуу Чин гүрэн *монгол улс, монгол иргэн* гэх мэт үг хэллэгийн оронд нийт Монголын хүн амыг заасан *монголчууд, монголууд* гэсэн үгсийг хэрэглэх болжээ.³⁶ Ийнхүү Чин гүрэн Монголын хүн амыг ердөө “монголчууд” гэж ангилан нэрлэв. *Аймгууд (улс болж)* Чин гүрэнд нэгтгэгдэхээсээ өмнө хаант улс, хан хөвүүдийн улс болон гарч ирсэн болохоор хүн ам нь тухайн аймгийнхаа нэрээр ялгагдан нэрлэгдсэн адилсал бүрдүүлсэн байх гэж бодож болох. Гэвч тийм бус. Сурвалжуудад Чингийн Гадаад Монголын (өнөөгийн Өвөр Монгол) хүн амын дунд “монголчууд” буюу “монголууд” гэдэгтэй адилаар хорчингууд,

³⁶ Munkh-Erdene, “The Qing transformation of Mongolia”. “Монголчууд”, “монголууд” хэллэгүүд нь манжуудын зохиосон нэр шиг санагдана. Эдгээр хэллэгүүдийн аль нь ч Чингийн эрхшээлд орохоос өмнө зохиогдсон монгол сурвалжууд болон XVII зууны монголын он дарааллын бичгүүдэд тохиолддоггүй. Харин 1652 оны *Дайчин улсын магад хууль* бол “монголууд”, “монголчууд” гэсэн нэрийн аль аль нь тохиолдож буй хамгийн эртний сурвалж болно. *Dayiching ulus-un magad hauli* (Qing veritable records), II, pp. 359, 545, 591-ийг үзнэ үү. Үүний дараа “монголчууд” гэх үг XVIII зууны монгол он дарааллын бичгүүдэд Ломигийн 1732 оны бүтээлээс эхлэн гарч байна. Lomi, *Mongol borjigid owgiin tüükh*, (Ulaanbaatar, 2006), pp. 14–16-г үзнэ үү. Монгол хэлний *улс* гэсэн үг дийлэнхдээ улс төрийн агуулгатай, тиймээс *Дайчин улс* гэдэгт тохиолдож байхад *иргэн* гэсэн үг хятадуудыг зааж хэрэглэгдэж байна. Гэхдээ ингэж нэрлэхийн гол шалтгаан нь Монгол улс төрийн категори буюу улс байхаа больсонд оршиж байгаа бололтой. Өөрөөр хэлбэл, Чин гүрэн байгуулагдсан явдал Монголд *улс* болон оршин тогтнох эцсийн цэгийг тавьж ердөө дүр эсгэсэн улс төрийн агуулгатай (quasi-political) орон болгон хувиргасан юм. Үнэхээр ч XVII зууны манж сурвалжууд, мөн 1696 онд хэвлэгдсэн *Монгол Цааз*-д гарч байдаг “Монгол улс”, “Гадаад Монгол улс” гэх нэршил XVIII зууны манж сурвалжуудад тохиолдохоо болино. *Tsaadjin bichig (Mongol'skoe ulojenie) Tsinskoe zakonodatel'sto dlya mongolov 1627–1694 gg.*, (ed.) and translated by S. D. Dylykov, (Moskva, 1998), pp. 16–17-г үзнэ үү. Тиймээс энэ нэршил 1789, 1816 онд тус тус баталсан *Хууль зүйлийн бичиг*-г огт гарахгүй. Харин “гадаад монголчууд” юм уу, “гадаад, дотоод монголчууд”, эсвэл “олон монгол аймгууд” гэсэн хэллэгүүд хэрэглэгдэнэ. В. Bayarsaikhan, (ed.), *Mongolyn tör, erkх züin tüükh* (deej bichig), volume 4. part 1, *Zarligaar togtooson Gadaad Mongolyn töriig zasakh yavdlyn yamny khuul' züilin bichig*, part 1, (Ulaanbaatar, 2008), pp. 39, 43-г үзнэ үү.

харчингууд, түмэдүүд, эсвэл ордосууд гэсэн үг огт дурдагддаггүй. Харин Хорчин, Харчин, Түмэд, Ордосын буюу "...-ны монголчууд" гэж л тохиолдоно.³⁷ Гэхдээ Халх, Ойрад, Цахарын хүн амыг халхчууд, ойрадууд, цахарууд гэж нэрлэж байгаа цөөн тохиолдол бий.³⁸ Цахар хошууд Чингийн Гадаад Монголын бүрэлдэхүүнд багтаагүй бол Халх XVII зууныг дуусах хүртэл тусгаар тогтносон хэвээр оршиж байв. Халхын хувьд түүнээс цааш харьцангуй салангид үлдэж, хангууд нь ч цолоо хадгалж үлдсэн. Ойрадууд бие даасан байдлаа хамгийн удаан хугацаанд хадгалж үлдэж чадсан. Гэвч дийлэнх эх сурвалж Халх монголчуудын тухай өгүүлсээр л байдаг. Монголчууд гэдгийн тухай сурвалжийн мэдээтэй харьцуулбал *аймгуудын* гарал үүслийн тухай ямар нэг домог юм уу, соёлын дүрслэл тайлбар олдохгүй.³⁹ Гэхдээ бүх хан хөвгүүн, хангуудын угсаа залгамжлалыг яах аргагүй *аймаг* нь тодорхойлж байжээ. Тийм ч учраас *Илтгэл шастир*-т *аймгийг* язгууртны өрхтэй адилтгасан байна. *Da Qing Yi tong zhi* 大清一統志 тэмдэглэлээс нэлээд мэдээлэл авч бичсэн уг бүтээлд монгол хан, ноёдын угсаа гарлыг тодорхой өгүүлсэн байдаг бөгөөд *аймаг, хошуудыг* тэдгээрийн хан, засаг ноёдын угсаатай нийлүүлэн бичсэн байдаг. Иймд "Хорчины өвөг болбоос Юань Тайзугийн дүү Хавт Хасар" гэх юм уу, "Цициг... Түшээт хан Ууба, Засагт жүн ван Будачийн хоёр хошууны өвөг болой... Намсрай... Дархан чин ван Манзушир, Бинт жүн ван Хонгор, бэйл Донгорын гурван хошууны өвөг", эсвэл "гадаад монголчуудын дунд Дөрвөд нэрт хоёр буй. Нэр адил боловч удам угсаа өөр. Нэг нь Чорос *овогтой*, Ойрадын ноён Буханы хойч... Нөгөө нь боржигид *овогтой*, Хавт Хасарын хойч" гэх мэтээр өгүүлдэг.⁴⁰ Гэвч сурвалжийг улам нягталбаас Хасар бол Хорчин аймгийн, өөрөөр хэлбэл энэхүү хүн ам бүхий эзэмшил газрын өвөг биш, харин Хорчины засаг ноёдын өвөг болох нь тодорхой мэдэгдэнэ. "Хорчины одоо буй зургаан засаг, мөн Жалайд, Дөрвөд, Горлос, Ар Хорчин, Дөрвөн хүүхдийн аймаг, Муумянган, Урад, Алашан, Хөх нуур, Хошууд цөм түүний [Хасарын] үр хойчис мөн".⁴¹

Тэгэхээр Чин гүрнээс Монголыг улс төрийн тусгаар тогтносон нэгдэл болохынх нь хувьд хэрхэн бутарган хуваасныг, ингэхдээ шатлан захирсан зохион байгуулалттай засаг захиргааны нэгж болж байсан *түмэн, отгийг* хэрхэн Чин гүрний харьяа дахь Гадаад Монголын алс зэлүүд дэд нэгж болгон хувирган өөрчилснийг авч үзлээ. Чин гүрний үеийн *аймаг* нь үнэндээ Чин гүрэн Монголыг нэгтгэхээс өмнө *түмэн, отог* гэсэн Монголын засаг захиргааны нэгж байсныг энд онцлон дурдах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, Монголын *түмэн, отог* нь

³⁷ Сурвалжуудыг бүрэн бус ч сайтар нягтлан шүүвээс эдгээр *аймгийнхныг* ерөнхийд нь монголчууд гэж нэрлэж байгааг харж болно. Гэхдээ хан хөвүүдийн гэр бүлийг, жишээлж хэлбэл Хорчины хан гэх зэргээр *аймгаар* нь тодорхойлж байсан. Тиймээс ийм *аймгууд* нь хүн амын бүлэг гэхээсээ илүү хан хөвүүдийн өрхийн эзэмшил гэсэн утга илэрхийлж байжээ.

³⁸ Munkh-Erdene, "The Qing transformation of Mongolia".

³⁹ L. Munkh-Erdene, "The Mongolian Nationality Lexicon: From the Chinggisid Lineage to Mongolian Nationality (From the seventeenth to the early twentieth century)", *Inner Asia*, VIII, (2006) pp. 51–98.

⁴⁰ *iletgel shastir*, pp. 138, 166.

⁴¹ Мөн тэнд, р. 138. Хэрвээ Чин гүрэн Монголын хүн амыг монголчууд хэмээн нэрлэдэггүй байсан бол Хасарын удмын хорчингууд гэдэг шиг хорчингууд, харчингууд, түмэдүүд, ордосууд гэх мэтчилэн ондоо өвөг бүхий ялгаатай бүлгүүд болгож нэрлэх байсан нь лавтай.

Даян хааны үр хойчис хувь болгон хувааж авснаас хойш хан хөвүүдийн өв залгамжилдаг эзэмшил болон улам бүр хувирч Чин гүрний үе хүргэсэн болно. Гэтэл *аймгууд* нь угсаа залгамжлал бүхий хан хөвүүдийн эзэмшил болохоор ямар нэг төр улсын шатлан захирдаг харьяат засаг захиргааны нэгж бус, харин улам бүр бие даасан эрх бүхий ноёдын засаг болон хувирч байжээ. Тэгвэл энэ байдал Монгол Чин гүрэнд нэгдсэн хойно юм уу, нэгдэхийн өмнө оршиж байсан бол Чингисийн угсааны улсын үе болон түүнээс өмнөх Дотоод Азийн хувьд ямар байдал оршиж байсан бэ?

Чингисийн угсааныхан Евразийг нэгтгэсэн нь: Мянган, Иргэнг буй болгосон нь

Дундад зууны үеийн Монголын бичгийн хүмүүсийн улс төрийн ертөнц *улс, иргэнээр* дүүрэн ертөнц байв. Тухайлбал, *Монголын нууц товчоонд* л гэхэд *улс (ulus)* гэдэг үг 106 удаа, *иргэн (irgen)* гэдэг үг бараг 200 удаа тохиолдоно.⁴² Гэхдээ “Монгол” гэсэн үг эдгээр хоёр үгийн аль алинаар тодотгуулж байхад Хятад, Тангуд гэх мэт тухайн үеийн бусад бүх улс төрийн нэгдэл буюу хүн амыг гагц *иргэн* тодотгоно. Монголоос бусад тухайн үеийн аль ч орны нэрэнд *улс* гэсэн үг дагалдахгүй агаад *улс, иргэн* гэх үгийг хэрэглэж буй энэ зүй тогтлоос нь л тухайн үед хэдийн тогтож хэвшсэн хэв маяг байсан нь сурвалжуудаас тод харагддаг.⁴³

Үгийн хэрэглэний хэвшиж тогтсон байдлаас дундад зууны монгол хэлний *улс* гэдэг нь угтаа ямар нэг газар орны нийтлэгийг ойлгохдоо засаглал гэсэн утга оноож хэрэглэсэн үг байсан бол *иргэн* гэдэг нь угтаа ямар нэг угсаа бүхий нийтлэгийг ойлгохдоо ямар нэг газар орны нийтлэг гэсэн утга оноож хэрэглэсэн үг байжээ. Өөрөөр хэлбэл, Монгол *улс* гэдэг нь улс төрийн агуулгатай нийтлэгийг заасан утгатай бол *иргэн* гэдэг нь хэл, ёс заншил, удам угсаа нэгтэй нийтлэгийг, энэ утгаараа орчин цагийн академик хэлэлцүүлэгт “угсаа-соёлын” айд хамаарагдах ямар нэг өгөгдсөн газар орны нийтлэг гэсэн утгатай ойлголт байв. Тиймээс монгол хэлний *улс, иргэн* гэх хоёр үг нь нэг зүйлийг хоёр өөр утгаар, ингэхдээ нэг нь улс төрийн, нөгөөх нь “угсаа-соёлын” талаас нь ухаж ойлгож хэрэглэсэн үгс болно. Ингэж үзвэл Монголоос бусад бүх тохиолдолд тийнхүү ойлгогдож буй тэмдэглэгдэхүүн нь дан *иргэн* буюу төргүй хүмүүс, тиймээс дүр эсгэсэн улс төрийн, бүр цаашилбал орчин цагийн академик хэллэгт “угсаа-соёлын” буюу аймгийн гэсэн утга агуулж байжээ.⁴⁴

Улс, иргэн гэсэн нэр томъёог хэрэглэж хэвшиж тогтсон байдал, эдгээрт оноож байсан салаа утга Монголын эзэнт гүрний ертөнцийн улс төрийн шинж чанарыг мөн тусган харуулж байна. Одоо мэдэгдэж буй бүх сурвалжийн бичигдсэн он цаг 1225-1226 оны дараах үед хамаарах тул сурвалжуудын бичигдсэн байдал эзэнт гүрний монголчуудын өөрсдийн улсын ертөнцийг үзэж байсан үзлийг тусган харуулна. Тиймээс бидний *МНТ* зэрэг бүхий л сурвалжаас уншиж буй зүйл бол

⁴² Munkh-Erdene, “Where did the Mongol Empire come from?”, pp. 213-215.

⁴³ Munkh-Erdene, “Where did the Mongol Empire come from?”

⁴⁴ Мөн тэнд, pp. 215-222.

эзэнт гүрний үеийн байдлыг түүний бүхий л өнгөрсөн түүхэн цаг хугацаанд хамааруулж төсөөлөн сэргээсэн зүйл болох буюу “буцаан хэрэглэж буй” (*ex post facto*) хэрэг болно. Үнэн хэрэгтээ МТН-ы зохиогч ийм эзэнт гүрний үеийн үзэл бодлоор харж, ийм онцлог бүхий тухайн цаг үеийн хэлээр ярьж байсан тул 1206 оноос өмнөх цаг хугацааг өөрийн эрхгүй мөн ийм л өнцгөөр харж, хэлж, бичиж байсан нь лавтай. Иймд сурвалжуудын зохиогдон бичигдсэн эзэнт гүрний үеийн цаг үед монголчуудаас бусад бүхий л газар орны нийтлэг эзэнт гүрний харьяанд орсон хүмүүс⁴⁵ буюу *иргэнд* тооцогдож байсан тул, тэдгээр бүх нийтлэгийг, үүнд бас 1206 оноос өмнөх цаг үеийн ч гэсэн нийтлэгийг *иргэний* байр суурьтай болгон бууруулж бичсэн байна.⁴⁶

Дийлдсэн, эзлэгдсэн улс төрийн нэгдэл тусгаар тогтносон улс төрийн нэгдэл байхаа больжээ. Ихэнх тохиолдолд тэдний бүрэн эрх, улс төрийн бүтэц устаж, нутаг дэвсгэр нь Чингисийн угсааныхны газар нутагт хамаарав. Өөрийн гэсэн улс төрийн бүтэц нь үгүй болсон хүн ам Чингис, түүний үр хойчсын байгуулсан улсын *мянган*, түүнээс салбарласан аравтын тогтолцоонд нэгдэв. Хэрэйд, Найман, Мэргид гэх мэт харьяанд орсон олон хүн амын зохион байгуулалтыг халж аравтын тогтолцоонд оруулж тараасан билээ. Ингэхдээ тэдгээрээс Чингисийн угсааныханд хамгийн үнэнч, дуулгавартайг нь *мянган*, *түмэн* болгов. Харин Чингисээс өмнө байсан бүх улс төрийн нэгдэл “дүр эсгэсэн улс төрийн” шинжтэй болж хувираад тусгаар тогтнол, бүрэн эрхтэй байсан улс төрийн оршихуй нь үгүй болсон юм. Мөн эдгээрээс зарим мянган нь дэд төр-засаг захиргааны байр суурьтай болж жижгэрсэн байдаг. Тухайлбал урьд ноёлж байсан Хэрэйд улсаас ердөө хэрэйд гэсэн адилсал нэртэй нөлөө бүхий хувь хүн, гэр бүл, удам угсаа үлдэж бусад нь өөр аравтуудад шингэжээ.

Нөгөө талаар, Чингис, түүний хөвүүд, үр ач нарын эрх мэдлийн байгуулал Монголын хүн амыг аравтаар зохион байгуулагдсан засаг захиргааны нэгж буюу цэргийн зохион байгуулалттай мянганд хувааснаар үе залгамжлан захирч, захируулдаг, цэргийн зохион байгуулалттай олон тооны хүн амын нэгжийг буй болгов. Ингэхтэй зэрэгцээд шинээр байгуулагдсан *улс* буюу Чингисийн угсааныхны төр тэр бүх нэгжийг өөртөө агуулсан хүн амдаа шинэ тогтоосон төрийн дээд эрх мэдлээ (*regnum, imperium*) тулган хүлээлгэв. Энэ нь улс төрийн урьд өмнөх адилслуудад ахин хуваарилалт хийж, тэднийг бутарган нэг бол “дүр эсгэсэн улс төрийн” хүн амын айд юм уу, үгүй бол дэд улс (*sub-regnum*) буюу дэд төрийн (*sub-state*) айд оруулан нэгтгэсэн хэрэг байжээ.⁴⁷

Иймд Чингисийн угсааныхны эрх мэдлийн байгуулал нэг талаар олон тооны дүр эсгэсэн улс төрийн адилсал, нөгөө талаар бас олон тооны цэргийн зохион байгуулалттай *мянган* байгуулжээ. Тэр бүү хэл шинэ *улс* буюу шинэ дээд эрх мэдэл болохынхоо хувьд өөрийн хүн амд нийтлэг улс төрийн адилслыг ч бий болгосон юм. Ингэхдээ зэрэг хэрэйдүүдийн тухай, тэдний улс төрийн нэгдлийн

⁴⁵ Соёл, ураг төрлийн утга агуулгатайгаас гадна *иргэн* гэдэг нь мөн удирдагч, эрх баригчаас ялгаатай, харьяанд орсон хүмүүс буюу захирагдагсад гэсэн утгатай нэрийдэл байв.

⁴⁶ Munkh-Erdene, “Where did the Mongol Empire come from?”, pp. 222-225.

⁴⁷ Мөн тэнд, pp. 222-225.

тухай ой санамж шинэ эзэнт гүрний түүх бичлэгт дүр эсгэсэн буюу улс төрийн бус (тиймээс угсаатан-соёлын) агуулгатай, эсвэл дэд юм уу, дотоод төрийн агуулгатай *иргэн*-ий ай болж шингэсэн ажээ.

Чингисийн угсааны улс, Чин гүрэн бүрэлдсэн явцыг шинжлэхэд адил төстэй хэл, загвартай байсан нь харагддаг. Чингисийн угсааны улс бүрэлдэхдээ өмнө нь оршиж байсан улс төрийн нэгдлүүдийг төргүй, тиймээс “дүр эсгэсэн-улс төрийн”, тэр дундаа “угсаа-соёлын” шинж чанартай *иргэн* болгон хувиргасан билээ.⁴⁸ Үүнтэй адил Манж Чин гүрэн бүрэлдэхдээ Монгол гэсэн газар орныг “монголчууд” гэсэн хүн ам болгон хувиргасан юм. Мөн Монголын *түмэн*, *отгийг* зах хязгаарын дагуул Гадаад Монголын гэгдэх тэргүүнгүй, тиймээс шатлан захирах ёсгүй, дүр эсгэсэн улс төрийн шинжтэй засаг захиргааны нэгж буюу *аймаг* болгон хувиргажээ. Хэрвээ *аймгийг* ийнхүү хүн ам байсан гэж авч үзвэл төргүй хүмүүс (stateless people) - аймгийн (tribe) шинжтэй дэд нэгжид хамаарагдаж таарна.⁴⁹

Тэгвэл эзэнт гүрний үед иргэн гэгдэж байсан улс төрийн олон нэгдэл Чингисийн угсааны эрх мэдлийн байгуулалд нэгдэхээсээ өмнө ямар байдалтай байсан бэ? Тэд Рашид ал-Дин зэрэг хожуу үеийн дээд боловсролтой бичгийн хүмүүсийн бичсэн шиг⁵⁰ овог, аймгийн шинжтэй байв уу? Язгууртны өрх гэр, тэдний эзэмшлийн шинжтэй байв уу? Эсвэл Чин гүрний өмнөх *түмэн*, *отогтой* төстэй дотроо шатлан захирах ёс журамтай улс төр-засаг захиргааны нэгж байсан уу? Ингэж үзвэл бие даасан удирдлагатай байсан болов уу? Эдгээр нэрийдэл, ойлголтуудын үүсэл гарал ямар байв? Чингисийн угсааны улс нэгдэхээсээ өмнө юу гэж нэрлэгдэж байв?

Чингисийн угсааны улсын өмнөх Дотоод Ази: Хятан гүрэн бүрэлдсэн хийгээд Зүбү-Хэрэйдийн ноёрхол

Угсаатны зүйн талаас Чингисийн угсааны улсын өмнөх Дотоод Азийн хүн амийн бүтэц Чин гүрний өмнөх Монголынхтой харьцуулбал хамаагүй олон янзийн бүрдэлтэй байсан боловч улс төрийн байгуулал нь тийм ч ялгаатай байгаагүй юм. Энэ нь тухайн цаг үеүүдэд аймгийн буюу язгууртны аль аль

⁴⁸ Мөн тэнд, pp. 215-225.

⁴⁹ Орчин цагийн судалгааны хүрээнд ийм дүр эсгэсэн улс төрийн шинж чанартай нэгжүүдийг (эсвэл мөхсөн улс төрийн нэгдлийн үлдэгдэл) ямагт аймаг (tribe) гэж авч үздэг. Гэтэл сонирхолтой нь, орчин цагийн нэг ч судлаач Монголын *хошуу* (буюу Монголын эзэнт гүрний үеийн *мянган*) аймаг гэж үзээгүй. Харин ихэнх судлаачид Чин гүрнээс өмнө оршиж байсан Монголын *түмэн*, *отгийг* аймаг гэж үзсэн байдаг. Тухайлбал, тухайн цаг үед орон нутгийн шинжтэй хүчирхэг хаант улс болон шинээр буй болсон Цахар, Халх, Хорчин зэрэг Чин гүрний өмнөх Монголын *түмэнгүүдийг* аймаг гэж, харин Чингийн үеийн хошуудыг хан хөвүүдийн эзэмшил (banner/principality) гэж бичсээр байна. Нөгөө талаар, Жалайд, Дөрвөд, Найман, Хэшигтэнг Чин гүрэн байгуулагдахаас өмнөх *отгууд* шиг аймаг (tribe) төдийгүй Чин гүрний үеийн *хошууд* шиг бас хан хөвүүдийн улс эзэмшил (banner/principality) гэж нэрлэж бичдэг. Гэтэл үнэндээ эдгээр монгол отог бүр Чин гүрний үед язгууртан гэр бүлийн удирдлага бүхий дангаар хошууг бүрдүүлж байсан билээ. Тэгэхээр орчин цагийн судлаачид тэдний байр суурийг аймаг болгон бууруулж байгаа нь эзэнт гүрний үеийн бие даасан байр суурийг нь давхар давхар бууруулан үнэлж буй хэрэг юм.

⁵⁰ ashā'ir (овог), qabā'il (аймаг), aqwām (ард түмэн буюу үндэстэн).

шинжийг агуулсан дэг журмууд давамгайлж байсантай холбоотой мэт санагдана. Харин энд миний дэвшүүлэхийг хүссэн гол асуудал бол Манж Чин гүрний өмнөх Монголын *түмэн, отгууд* нь өөр хоорондоо зэрэг дэв үүсгэн захирагдсан улс төр-засаг захиргааны нэгж байсан агаад Чингийн өмнөх Монгол хэдийгээр Юань гүрнээс үлдэж хоцроод бутран задарч, олон хэсэгт хуваагдсан байсан ч нэг бүхэл улс орон болж байсан, тиймээс энэ утгаар авч үзвэл Чингисийн угсааныхны өмнөх Дотоод Азийн улс төрийн байгуулал нь Чингийн өмнөх байгуулалтай төстэй байсан гэсэн асуудал юм. Цахар Умард Юань улсын нутгийн хувьд зүй ёсны тэргүүлэгч түмэн болж байсантай адил Хэрэйд тухайн цаг үеийн Монголын нутаг дахь улс орны зүй ёсны тэргүүлэгчийн үүрэг гүйцэтгэж, харин Найман, Мэргид, Татар, Монгол, Ойрад зэрэг нь тэрхүү улс орны засаг захиргааны нэгж, магадгүй харьцангуй өөртөө бие даасан шинжтэй нэгж болж байжээ.⁵¹

1206 онд Их Монгол улс байгуулагдсантай холбоотойгоор хэвшиж тогтсон *улс* гэх ойлголт түүнээс өмнөх Дотоод Азид ч гэсэн хэрэглэгдэж байсан ба үнэн хэрэгтээ 1206 онд Чингисийн төр Хэрэйдийн төр, түүний ноёрхлын хүрээний суурин дээр байгуулагдсан юм.⁵² Судлаачид Чингисийн өмнөх Монголд Хэрэйд улс нэлээд төвлөрсөн эрх мэдэлтэй байсан болохыг онцлон тэмдэглэжээ.⁵³ Тухайлбал Паул Рачневский бээр Тэмүжинг “Хэрэйд улс”-ыг устгаж Хэрэйдийн хаан ширээнд суусан гэж хүртэл бичсэн байдаг.⁵⁴

Хэдийгээр Монголын эзэнт гүрний сурвалжууд өмнөх үеийн нөхцөл байдлаа гуйвуулан бичсэн байдаг ч анхааралтай судалж үзвэл Чингисийн улс байгуулагдахаас өмнөх Дотоод Азид нэгэн бүхэл “эсгий туургат *улс*”-ын тухай үзэл санаа оршиж байсан болох нь тодорхой мэдэгддэг төдийгүй Чингисийн угсааны улс байгуулагдахаас өмнөх Монгол Хэрэйдийн төрийн дор сарниж бутарсан ч нэгэн бүхэл улс орныг бүрдүүлж байсан гэсэн санаа дэвшүүлэх боломж олгож байна. *MHT*-д мэдээлснээр 1201 онд Эргүнэ мөрний эрэгт Монголын тал нутаг дээрх гол улс төрийн бараг бүх нэгдлийн тэргүүнүүд чуулж Жамухыг Гүр ханд (*gür-qa[n]*) өргөмжилжээ. Гүр ханд өргөсөн хүмүүсийн дотор Найманы Буюруг хан, Ойрадын Хутуга бэхи, Татарын Жали-буха Мэргидийн Тогтога-бэхийн хөвүүн Хуту, Тайчуудын Таргудай Хирилтуг нар байв.⁵⁵ Гүр хан Он хан, Тэмүжин хоёрт дайн зарлаж, харьяандаа нэгтгэхээр тэр даруй морджээ. Гэвч түүний аян дайн бүтэлгүйдсэн. Гүр хан байлдаанд ялагдсан төдийгүй хүч нь бутарсаар улс нь мөхсөн юм.

Гүр ханы хувь заяа дутаж төр нь мөхсөн, гэвч түүний үйл хэрэг “эсгий туургат *улс*”-ын язгууртнуудын дунд оршиж байсан маш чухал улс төрийн

⁵¹ “Хэрэйдийн Он хан”-ыг хүч чадал нь нуран унасан улсын зүй ёсны сүүлчийн, гэхдээ эрх мэдэл нь сарнин багассан хаан байсан гэж Чингисийн угсааны улсын үеийн сурвалжуудад дурддагтай адил Монголын сүүлчийн Их хааныг “Чахарын Лигдан хаан” гэж доршоон нэрлэж байсан. Munkh-Erdene, “The 1640 Great Code”-ийг үзнэ үү.

⁵² Munkh-Erdene, “Where did the Mongol Empire come from?”.

⁵³ P. Rachnevsky, *Genghis Khan: His Life and Legacy*, T. Haining translator and (ed.) (Oxford, 1991), Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, pp. 295–296-г үзнэ үү.

⁵⁴ Rachnevsky, *Genghis Khan*, pp. 78–83.

⁵⁵ I. de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols* (Bloomington, IN., 1972), p. 61.

нэгэн үзэл санаа буюу “эсгий туургат улс”-ыг бүхэлд нь захирдаг хаан гэж байсныг илтгэдэг. Энэ нь чухамдаа “эсгий туургат улс” бүхэлдээ нэгэн улс орныг бүрдүүлж, түүний бүрдэл хэсгүүд засаг захиргааны нэгж болж байсан гэсэн үг юм. Он хан, Тэмүжин хоёрын аль аль нь ингэж үзэж байсан, гэвч тэдний хувьд Жамуха бүгдийг захирагч хаан биш байжээ. Харин тэдний Гүр хан буюу зүй ёсны хаан нь Он хан, харин Жамуха түүний хаан ширээнд санаархагч байсан бололтой.

Хувь дутсан Гүр ханаас бусад “эсгий туургат улс”-ын нэг ч хаан Он ханаас (Wang Khan) илүү дээр цолтой байсангүй. Он ханы өмнөх, өөд болсон хан Гүр хан цолтой байсан бол Он ханыг залгамжлагч катайн (хятан) хэлээр хан хөвүүн гэсэн утгатай “Сангун”⁵⁶ гэж нэрлэгдэж байв.⁵⁷ Харин Найманы Таян ханы авсан хамгийн өндөр цол бол “хан хөвүүн” гэсэн утгатай Тай Ван байв.⁵⁸ Ван ханы цол, түүний болон Тэмүжин хоёрын Алтан улсаас хүртэж байсан *ja'ut quri* [зуутын даргач] цол нь тэрхүү улс орны дотор эзэлж байсан тэдний харьцангуй байр суурийг илтгэн харуулна.⁵⁹ Тиймээс л “Хорвоод хоёр хан хэрхэн байж болох буй?” хэмээн Таян ханы дуу алдсан явдал⁶⁰ ийм бүгдийг захирагч хаан байсныг илтгэхийн сацуу Тэмүжин Он ханы эсрэг босож “хан болох” гэлээ хэмээн буруутгасан нь ч Он хан бол тийм бүхнийг захирагч улсын хаан байсныг нотолно.⁶¹ Энэ бүгд Он хан бол зүгээр ч нэг өндөр цолтой удирдагч хүн байсныг бус, харин улсын бүгдийг захирагч хаан хүн байсныг харуулж байгаа юм.

Түүнчлэн *МНТ* уг нөхцөл байдлыг улам тодруулж Жамухыг хаан ширээнд санаархагч гол хүн, харин Тэв Тэнгэр, Хасарыг Тэмүжиний *улсын* хаан болох гэсэн хэрэгт багахан саад учруулагч байсан гэж өгүүлж байхад *Судрын чуулган* Жамуха, Хасар, Сача Бэхи, Мэргидийн Алаг-Удурыг цөмийг нь Тэмүжинтэй адил улсын хаан болохын төлөө өрсөлдөгчид гэж өгүүлдэг.⁶² Гэтэл эдгээр сурвалжийн аль нь ч Он ханыг өрсөлдөгч юм шигээр бичээгүй. Энэ нь Он хан “Монгол”-ын *de jure* хаан байсан, түүний ширээнд залуу захирагч нар тэмцэлдсэн болохыг харуулж байна. Мөн *Судрын чуулган*-д Нилха сэнгүм Тэмүжинд дайсагнаж “Тулалдъя, бидний хэн нь гарсан хан болох болно” хэмээн өгүүлсэн ч хаан

⁵⁶ Үнэндээ *МНТ*-д Сангун буюу *senggüm* нь түүний цол болно. Нэр нь Nilqa, тиймээс Нилха-сэнгүм гэж хэдэнтээ гардаг. de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, pp. 77-79-ийг үзнэ үү. *Senggüm* буюу *xiangwen* (хятадаар захирагч гэсэн утгатай *xianggong*) бол “аймаг” буюу засаг захиргааны нэгжүүдийг захирагч гэсэн утгатай хятан цол болно. Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 317-г үзнэ үү.

⁵⁷ Rashiduddin, *Compendium of Chronicles*, p. 175.

⁵⁸ Мөн тэнд, p. 69. Инанча-хан Он ханг Хар Хятан руу хөөсний дараа Найман улс тэргүүлэх байр суурьтай болж ирсэн бөгөөд Таян ханы цол нь яах аргагүй тэрхүү тэргүүлэх байр суурийг илэрхийлэх цол мөн.

⁵⁹ de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 57, Rashiduddin, *Compendium of Chronicles*, p. 165-ыг үзнэ үү.

⁶⁰ *Судрын чуулган*-д “Энэ хорвоо дээр нэг улсад хоёр хаан зэрэгцэн оршиж хэрхэн болох буй?” гэж гардаг. Rashiduddin, *Compendium of Chronicles*, p. 201-ийг үзнэ үү.

⁶¹ “ötögü yeke erten-ü ong-qan-ni qor-iyar-iyar aчу'ulju ükü'ülba edö'e mün qan bolsu ke'en aqun-u... qajar de'ere qoyar qat ker bolqu”. de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 98-ыг үзнэ үү.

⁶² Rashiduddin, *Compendium of Chronicles*, p. 181. Мөн Жамуха, Хасарын тухайд de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 50, 139-140-ийг үзнэ үү. Алаг-Удур *МНТ*-д огт гардаггүй.

болохоор санаархагч хүмүүсийн тэргүүлэх эгнээнд Нилха сэнгүмийг оруулаагүй байдаг нь тэр бээр Он ханыг залгамжлагч байсантай холбоотой юм.⁶³ Мэдээж хэрэг, Нилха сэнгүм өв залгамжлагч учир хаан ширээнд өрсөлдөхгүй, харин зүй ёсоор ширээнд суух хүн байжээ. Хэрвээ Он хан, Нилха сэнгүм хоёр зүй ёсны хаан, түүнийг залгамжлагч хүмүүс биш байсан бол тэднийг сурвалжууд хаан ширээнд өрсөлдөгчийн жагсаалтад оруулах байсан нь лавтай. Тиймээс Хэрэйдийн хаан ширээ бол түүнд өрсөлдөгч хүмүүсийн эцсийн зорилго байсан аж.

Үнэн хэрэгтээ Он ханы өвөг дээдэс (магадгүй өвөг эцэг юм уу, элэнц эцэг) Хятан улсаас харьцангуй “бие даан” оршиж байсан, түүхэнд Зү-бү (Tsu-pu буюу Zubu) хэмээн нэрлэгдсэн улс орны мэдэгдэн буй хамгийн анхны хаадын нэг байв.⁶⁴ Рашид ал-Дины өгүүлснээр Он ханы өвөг эцэг Маркуз (Marcus буюу Markos) Буюруг хан буюу Хэрэйдийн хааныг Татарын Наур Буюруг хан олзолж бариад “Катай, Зүрчидийн хаадад аваачин” дагуул болгосон ба “зүрчидүүдийн хаанд одохуйд түүнийг модон илжгэнд хадаж алжээ”.⁶⁵ Ляо улсын сударт өгүүлснээр 1089 онд Хятан улс “харьяат улс” болох Зүбүгийн удирдагч Мэгүсү (Mo-ku-ssü) “олон аймгийн ахлагч”-аар буюу илүү оновчтой хэлбэл Зүбүгийн Их ханаар томилжээ (хүлээн зөвшөөрсөн гэвэл зохистой). Учир нь Ляо улс Зүбүг “харьяат улс”, удирдагчийг нь “Их хан” гэж үздэг байв.⁶⁶ Харин Мэгүсү төд удалгүй Ляо улсыг дайран 1093 онд дийлэнх цэргийг нь дараад 1100 онд Елюй Утэлад (Yeh-lü Wo-t'ê-la) олзлогдохоосоо өмнө Ляо улстай дайтсаар байжээ. Түүнийг ч бас Ляо улсын хааны ордонд илгээж “зах дээр хэдэн хэсэг тасчин нөгчөөсөн”. Энэ Мэгүсү гэгч Татарын удирдагчаас урван одсон Маркуз Буюруг хан байсан нь гарцаагүй.⁶⁷ Тиймээс Хэрэйд улс, түүний тал нутаг дахь улсуудыг ноёлж байсан цаг үе дор хаяж XI зууны төгсгөлд (хятанчууд Монголыг байлдан дагуулахаас өмнө) холбогдох ёстой. Ингэж үзвээс МНТ-д дурдсанчлан Он хан үнэхээр “эртний өтөг их хан” болох юм.⁶⁸

⁶³ Rashiduddin, *Compendium of Chronicles*, p. 190.

⁶⁴ Монголыг нэрлэсэн төвөд Sogro гэсэн үг Tsu-pu (Zubu) гэсэн үгээс гаралтай гэвэл Зүбү нь хаан улсын нэр байсан гэж үзэж болох юм. Тийм бол Хэрэйд гэдэг нь Цахар гэдэгтэй адил түүний засаг захиргааны нэгжийн нэрийдэл байсан болж таарна. Чингисийн угсааны улсын үед Он ханы байр суурийг доршоож бичсэн нь учиртай. Хэрвээ ингэж үзвэл Монгол нутагт оршиж байсан улсын нэр Зүбү бус харин Монгол байсан байх ёстой. Сүн улсын элчин Жао Хун 1221 оны орчим Мухалийн цэргийн хүрээнд саатаад “монголчууд” өөрсдийгөө татар гэдэг, мөхөөд удсан нэгэн их улсын нэрээр төр улсаа Их Монгол улс буюу *da menggu guo* (大蒙古國) хэмээн нэрлэдэг гэж бичсэн байдгийг дурдах нь зүйтэй. N. Munkuev, *Men-da bei-lu, Polnoe opisanie Mongolo-Tatar* [Монгол Татарын бүрэн тэмдэглэл] (Moscow, 1975) pp. 53, 249.

⁶⁵ Rashiduddin Fazlullah, *Jami' u't-tawarikh: Compendium of Chronicles*, pp. 62-63.

⁶⁶ A. K. Wittfogel, Fêng Chia-Shêng, *History of Chinese Society Liao (907-1125)* (Philadelphia, 1949) pp. 101-102, 317, 593. Зүбүгийн удирдагчийн уг цол нь хан байсан нь ойлгомжтой.

⁶⁷ Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, pp. 295-297.

⁶⁸ de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 97-ыг үзнэ үү. 924 онд Хятан улсыг үндэслэгч Абаожи хаанд ялагдсан ч гэсэн Зүбү улс Хятан улстай байнга дайтан хятаны нөлөөг баруун тийш шахаж байв. Үүнээс үзвэл Зүбү улс Хятан улстай эн зэрэгцэхүйц хүч чадалтай улс байсан нь лавтай. Абул Фаражийн бичсэнээр Хэрэйд улсын хан 1007 онд христийн шашинд орохдоо 200,000 харааттай байсан ажээ. Togan, *Flexibility and Limitation in Steppe Formations*, pp. 60-61, Atwood, *Encyclopedia*

Чингисийн угсааны улс шууд Хэрэйд улсын суурин дээр байгуулагдсан агаад Хэрэйдээс төрийн байгууллага авч хэрэглэсэн ажээ. Он ханыг унагасныхаа дараа Чингис хан аравтын зохион байгуулалтыг зээлж, 6 *cherbi*, 80 *kebte'ül*, 70 *turqa'ut*-аас бүрдсэн *kesikten*, 1000 *ba'atut*-аас бүрдсэн манлай цэрэг гэх мэт албуудыг байгуулав.⁶⁹ Эдгээрээс *турхаг*, *баатар* хоёр нь гарцаагүй Хэрэйдийн байгуулал байжээ.⁷⁰ Он хан үүнээс ч том турхагийн (1000 турхаг) хүчтэй байсан агаад “мөн тийм тооны хэвтүүлтэй байсан байж магадгүй”.⁷¹ Тэгвэл баатрын хүч нь бүр ч том байсан байж магадгүй.⁷² Он ханы цэрэг *minqan turqa'ut*, *tümen-tübege* (10,000 төвийн буюу 10,000 довтлох цэрэг?) хэрэйд гэх мэт аравтын тогтолцоогоор зохион байгуулагдаж байжээ. Иймд Чингисийн угсааны төр улс Хэрэйдийн төр улсын суурин дээр байгуулагдсан учир үүнийг залгамжлагч улс гэж ч нэрлэж болох байна. МНТ-д өгүүлсэнчлэн Чингис хан өөрөө “Мөнх тэнгэрт ивээгдэж хэрэйд иргэнийг доройтуулж өндрийн оронд хүрэв зэ” хэмээн хүлээн зөвшөөрч байжээ.⁷³

Питер Голден, Никола де Космо зэрэг олон эрдэмтэн Дотоод Азийн эзэнт гүрнүүдийн аравтын тогтолцоо гэх мэт улс төрийн уламжлалуудын залгамж чанарын тухай анхааран судалсан байдаг бол Хансгерд Көкенжан бээр Хүннү, Сяньби, Түрэг, Хятан Ляо, Алтан, Монгол, Төмөрийн угсааны эзэнт гүрнүүд аравтын тогтолцоог авч хэрэглэж байсан тухай баримтуудыг уйгагүй цуглуулжээ.⁷⁴ Эдгээр олон эзэнт гүрэн мандан бадармагц Монголыг шууд захирч байсан бол Алтан улсын “хуваан захирах” бодлого нэвтрэхээс өмнө Хятан улс ч гэсэн Монголын үлэмж хэсгийг шууд ноёрхож байв.

Монголын дорнод хэсгийн ихэнх хоёр зуу гаруй жилийн турш Ляо улсад шууд захирагдаж, харин үлдсэн хэсэг нь ямар нэг хэмжээгээр нөлөөнд нь оршиж байсан билээ. Ляо улс Монголд Жэньжоу, Хэдун буюу Кэдун зэрэг цэргийн бэхлэлт хотуудыг 1004 онд байгуулан орон нутгаас 20,000 цэрэг татаж суулгаж

of Mongolia and the Mongol Empire, p. 296-г үзнэ үү.

⁶⁹ de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 99-100, Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 297-г үзнэ үү.

⁷⁰ de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 81-82-ыг үзнэ үү.

⁷¹ Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 297.

⁷² de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 81-82-ыг үзнэ үү.

⁷³ “mōngke tenggeri-de ihe'ekdejü kereyit irge doraida'ulju üндүр-ün oron-tur gürba-je”. de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 96-г үзнэ үү.

⁷⁴ P. Golden, “Imperial ideology and the sources of political unity amongst the pre-Chinggisid nomads of Western Eurasia”, *Archivum Eurasiae Medii Aevi*, II (1982), pp. 37–77; “Nomads and their sedentary neighbors in pre-Chinggisid Eurasia”, *Archivum Eurasiae Medii Aevi*, VII (1991), pp. 43–44; N. di Cosmo, *Ancient China and Its Enemies: The Rise of Nomadic Power in East Asian History* (Cambridge, 2004); H. Cöckenjan, “Zur Stammesstruktur und Heeresorganisation Altaischer Völker Das Dezimalsystem“ in *Europa Slavica – Europa Orientalis: Festschrift für Herbert Ludat zum 70 Geburtstag*, (eds) Klaus-Detlev Grothusen and Klaus Zernack (Berlin, 1980), pp. 51–86. Сонирхолтой нь, Көкенжан мөн Огузын 24 аймаг, 24 түмэн, Булгар-Түрэгийн Он-Огурын “арван аймаг”, “арван сум” зэрэг хэд хэдэн тохиолдолд “аймгууд”-ын тоо хийгээд “арван мянган” гэх мэт аравтын нэгжүүдийн тооны хооронд харилцаа холбоо буйг тогтоожээ. (Cöckenjan, 1980), pp. 56-59-ийг үзнэ үү.

байв.⁷⁵ Ляо улсын баруун тийших тэлэлтийг хянаж байсан Зүбү улсын тэргүүн нь Их хан байж “харьяат улс”-ын байр суурьтай оршиж байжээ. Монголын үлдсэн хэсэг “аймаг”-аар зохион байгуулагдаж, “хааны 54 аймаг”-ийн хэсэг нь Ляо улсын “Умардын яам”-ны мэдэлд оршиж байв.⁷⁶ Эдгээр 54 “хааны аймаг”-ийн бараг 10 нь, мөн “гадаад”, “олон аймаг”-уудын 24 орчим нь монгол гаралтай, Монголд оршиж байсан нь мэдэгдсэн.⁷⁷ “Аймгуудыг засаг захиргааны хувьд Хятаны *senggüm* (*xiangwen*, хятадаар *xianggon* буюу захирагч) захирч, түүнд *lingqu* (*lingwen*, хятадаар *linggong* буюу даргач) болон алба тусална.”⁷⁸ *Senggüm*, *lingqu* хоёр түшмэд Чингисийн өмнөх Монголд байсныг сурвалжууд нотолдог.⁷⁹ Мөн Нилха сэнггүмээс гадна Чарахай лингху, Сэнггүм Билгэ нарыг *МНТ*-д дурддаг.⁸⁰ Энд Чарахай лингху, Сэнггүм Билгэ хоёр бол эцэг хүү хоёр байв. Үүнээс Чарахайгийн хөвүүн Билгэ захирагч болон дэвшиж, эцэг нь түүнд туслахаар томилогдсоныг тодорхой мэдэж болно. Билгийн хөвүүн Амбагай Хабул хааны дараа “Хамаг Монгол”-ын хан болон өргөмжлөгдөж байгааг ч мөн дурдаж болно.⁸¹ Тэр бүү хэл “бүдүүлгүүд” Хятаны эзэн хааны *ordo* (ордны) цэргийн чухал хэсгийг бүрдүүлж байсан бол Музун хааны *ordo* бэхлэлтэд Зүбү аймгийнхан багтаж байсан нь илэрхий байна.⁸²

Гэхдээ Ляо улсын “аймаг”-ууд дээрээс доош зэрэг дэвээр жагсаж байв. Карл Виттфогелийн үзсэнээр Ляо улсын хаад 54 “аймаг” (*bu* 部) байгуулсан ажээ. Хятан хаад “харьцангуй том аймгууд”-ыг олон жижиг “аймаг”-уудад хуваагаад “аймгийн байр суурь”-ийг халж, “жижиг хэсэг, тэр бүү хэл хүмүүсийг цуглуулан шинэ аймгуудыг байгуулж”, тэдэнд “аймгийн байр суурь олгов”.⁸³ Тухайлбал, “Хятаны эртний найман аймаг бүр цэргийн тусгай бэхлэлт байгуулахад хорин өрх нийлүүлж, тэр нь өргөсөн томорсоор Тэли-тэ-миэнь аймаг үүсэв” гэсэн

⁷⁵ M. Biran, *The Empire of the Qara Khitai in Eurasian History: Between China and the Islamic World*, (Cambridge, 2005), p. 27, Wittfogel, Fêng, *History of Chinese Society Liao*, p. 46. Жэньжоу хот нь одоогийн Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь Чинтолгойн балгас, Хэдун нь Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших Зүүн хэрэм нь болох нь нотлогдсон. Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 317.

⁷⁶ Wittfogel, Fêng, *History of Chinese Society Liao*, p. 453.

⁷⁷ Олон судлаач Урианхан, Мэргидийг нэрлэдэг. Харин Онгирад, Жажирад, Найманы тухайд тодорхойгүй. Wittfogel, Fêng, *History of Chinese Society Liao*, pp. 87-100-г үзнэ үү.

⁷⁸ Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 317-г үзнэ үү.

⁷⁹ *Taishi*, *tekin*, *tarqan* зэрэг өөр бусад хятан цол ч Чингисийн өмнөх Монголд хэрэглэгдэж байсан. Эдгээр хятан цолуудын тухай Wittfogel, Fêng, *History of Chinese Society Liao*, pp. 442-445-аас үзнэ үү. *МНТ*-д Нэгүн тайш, Хадаан тайш (хоёул монгол), Алин тайш, Хори-Силэмүн тайш, Тай-төмөр тайш (цөм хэрэйд) гэсэн нэрс олдоно. Тай-төмөр нь Он ханы амь үрэгдсэн ах байв. de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 21-22, 71, 82-83, 87-г үзнэ үү.

⁸⁰ de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 21, 91.

⁸¹ Мөн тэнд, p. 22.

⁸² Монгол хэлний *ordo* гэсэн үг хятан хэлний *ordo* гэсэн үгээс үүссэн эсэх, “аль аль нь эртний нийтлэг үгийн ялгаатай хувилбар” байсан эсэхийг нотлоход бэрх. Гэвч Монголын газар нутгийн үлэмж хэсэг хүн амын хамт Хятаны хэсэг болж байсан, үлдсэн хэсэг нь Хятаны ноёрхлын нөлөөнд оршиж байсан үед монгол хэлний *ordo* гэсэн үг хятан хэлний нөлөөтэй хэрэглэгдэж байсан болов уу. Wittfogel, Fêng, *History of Chinese Society Liao*, pp. 21, 55-ыг үзнэ үү.

⁸³ Мөн тэнд, pp. 46-48, 85-86.

тохиолдол байна.⁸⁴ Тэр бүү хэл, хятан хаад дагаар оруулсан хятан бус аймгуудыг “хятан” аймгуудад тараан хольсон тул Тайзугийн арван найман аймгийн долоо нь “цөм холимог” шинжтэй байжээ.⁸⁵ Тиймээс Виттфогель “синтетик аймаг” буюу “холимог” гэх мэт нэр томьёог хэрэглэж, “*Tsu* [族 ураг], *pu* хоёр нь хятаны нийгмийн өвөрмөц, заримдаа танил бус шинж талуудыг нэрлэхэд ойролцоогоор оноож өгсөн хятад нэрийдлээс өөр зүйл бус юм. *Pu* гэсэн нэр томьёог аймаг гэсэн утгатай *pu-lo* 部落 гэсэн үгтэй адил утгаар хэрэглэсэн. Үүнийг орон нутгийн бүлэг хүмүүс юм уу, засаг захиргааны нэгжийн аль аль утгаар хэрэглэж болдог” гэж тайлбарласан байна.⁸⁶ Ингээд Виттфогель аймгийг “цэрэг дайны хамтын үйлдэл хийх хэрэгцээгээр өөр зуураа нэгдсэн, тодорхой нэг тэргүүн ахлагчаар удирдуулсан олон тооны орон нутгийн бүлгүүдийн нэгдэл” хэмээн тодорхойлжээ.⁸⁷ Ляо улсын ийм “аймаг”-ууд дотроо олон хэсэгт хуваагдаж байсны хамгийн бага нэгж нь *chao* буюу “зуут” байв.⁸⁸ Ийм учир шалтгаанаар Хятаны эрхшээлийн үеийн Монголын хүн ам түүний дээрээс доош тогтсон зэрэг дэв бүхий засаг захиргааны нэгжид хуваагдаж байсан ажээ.

Монгол дахь Хятан улсын нөлөө удаан үргэлжилсэн мэт санагдана. Ляо улсын өрнө зүг тийших тэлэлтийг байнгын дайн тулаан хийж тогтоон барьж байсан хүчирхэг Зүбү улс ч гэсэн Хятаны “хуваан захирах” бодлогод хохирол амсжээ. Ляо улсын хаан Шэнзун 983 онд Зүбүгийн эсрэг аян дайн хийснээс үүдсэн хориод жилийн үймээн самууны дараа Ляо улсын хаан 1003 онд Зүбүгийн ханыг олзолж, “улсыг нь хэдэн хэсэгт хуваан бутаргаад, тус бүрийг хятан цэргийн захирагчид хамааруулжээ”.⁸⁹ Хожим нь Ляо улс Маркузтай тулалдахдаа 1092 онд “аймгийн цэргүүд”-ийг түүний эсрэг хөдөлгөж, Маркузын өмнөх олон холбоотныг түүний эсрэг ашиглан ялсан.⁹⁰ Түүгээр ч барахгүй Хар Хятан улсыг үндэслэгч Елюй Даши Хятаны цэргийн бэхлэлт Хэдунд 1124-1130 онд байршиж, тэднийг өөрийн мэдэлд “долоон тойрог” болгон зохион байгуулж байсан аж.⁹¹ Эрдэмтэд 1124 онд Елюй Дашийн харьяанд байсан “арван найман аймаг”-ийн заримыг мэдэж чадсан нь тун сонирхолтой.⁹² Тэдгээр олон аймаг (угтаа засаг захиргааны нэгж буюу харьяаны орнууд) үнэхээр байсан юм гэвэл өвөрмөц адилсал бүхий доороос дээш зохион байгуулагдсан бүлэг гэхээсээ илүү дээрээс доош зохион байгуулагдсан “синтетик” буюу “холимог” шинжтэй бүлэг байсан нь тодорхой. Тиймээс Ляо улсын “хуваан захирах” бодлогын нөлөө Монголд удаан хугацаанд хадгалагдсан хэвээр үлджээ.

⁸⁴ Мөн тэнд, р. 48.

⁸⁵ Wittfogel, Fêng, *History of Chinese Society Liao*, pp. 46-48.

⁸⁶ Мөн тэнд, р. 47.

⁸⁷ Мөн тэнд, р. 46.

⁸⁸ Мөн тэнд, pp. 444-445.

⁸⁹ F. Mote, *Imperial China 900-1800* (Cambridge, MA, 1999), p. 57.

⁹⁰ Wittfogel, Fêng, *History of Chinese Society Liao*, pp. 362, 518, 593-594.

⁹¹ Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 317, Biran, *The Empire of the Qara Khitai in Eurasian History*, pp. 26-33-ыг үзнэ үү.

⁹² Biran, *The Empire of the Qara Khitai in Eurasian History*, pp. 26-33.

Ляо улсын дараа Алтан улс, Хар Хятан улс аль аль нь Монголыг хуваан захирах бодлого хэрэгжүүлсэн билээ. Эдгээр хоёр улс хоёул, үүнд Алтан улс Татарт, Хар Хятан улс Найманд, хил орчмын газар нутгууддаа нөлөөгөө тэлсэн бөгөөд тэднийг улам хүчирхэгжиж буй Хэрэйд улсын хүчийг хумихад олон удаа ашиглаж байсан юм. Тиймээс татарууд хэрэйдүүд болон түүний харьяаны монгол аймгуудтай байнга дайтаж, Найман улс Он ханыг шахан дутаалгаж байгаа нь сурвалжуудад дурдагджээ. Хариуд нь Хэрэйд улсын хаан Хар Хятан, Алтан улс, Тангуд улс зэрэг өөрийг нь тойрон хүрээлсэн улсуудтай тун ч идэвхтэй тулалдаж аль алинтай нь хүчний тэнцвэрээ хадгалахаар хичээж байжээ. Үнэндээ Он хан бол тун ч чадварлаг хаан байсан бололтой: Тэр бээр Хэрэйдийн ноёрхлыг тогтоож чадсанаар барахгүй Хар Хятан, Алтан улс хоёрын хагалан бутаргах оролдлогуудтай тулгарахын зэрэгцээ Ляо улсын үлдээсэн хагалан бутаргах үйл явцыг няцааж чадсан ажээ. Монголын эзэнт гүрний үеийн сурвалжуудыг шүүмжлэлтэйгээр нягталбаас Тогрил бол Мэргид, Татар, Гүр хан, Найман, Монголыг дагаар оруулахын тулд тасралтгүй аян дайн хийж байсан хүн нь яах аргагүй мөн болох нь мэдэгдэнэ.⁹³ Тэгэхээр ийм хүнд бэрх үед Тогрил Монголд Хэрэйдийн ноёрхлыг сэргээн тогтоож чадсан учраас л нэгэн цагт өвөг эцэг Маркуз нь Алтан улсаас авч байсан цолтой төстэй улсын хан буюу Ван цол хүртсэн ажээ. Гэвч түүнээс салан тусгаарласан дагуулуудын нэг хаан ширээ, улсад нь санаархаж, хуримлан санаандгүй байх ахуйд нь шөнө дүл гэнэдүүлэн дайрч эзэлсэн билээ.⁹⁴

Иймд Чингисийн өмнөх Монголын нөхцөл байдал Чин гүрний өмнөх Монголынхтой маш төстэй байсан гэж хэлж болно. Монгол энэ үед Хэрэйд улсын ноёрхолд тархай бутархай, олон хэсэгт хуваагдсан улс орон байв. Алтан улс, Хар Хятан улс тус бүс нутгийг хагалан бутаргах бодлого хэрэгжүүлсээр байсан бол Хятан улсын үед оршиж байсан цэргийн зохион байгуулалттай “аймаг”-уудын нөлөөгөөр олон жижиг “синтетик” буюу “холимог” цэргийн нэгжүүд үлдэж хоцорсон байжээ. Чингисийн өмнөх Монголын улс төрийн нэгдлүүдийн тэргүүд *senggüm, lingqu, buyuruq, beki, bahadur, ja’ut quri*⁹⁵ зэрэг цэргийн буюу цэргийн зохион байгуулалттай цолуудтай байгаа явдал нь ч гэсэн тэднийг ямар нэг илүү том эрх мэдлийн харьяат, дагуул байр суурьтай байсан, засаг захиргааны нэгж

⁹³ de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 42-48, 57-58, 61-63, 74. МНТ-ы үйл явдлуудын дарааллыг мөшгин судалбаас Чингис ханы цэргийн амжилт нь ихгүй байсан гэсэн дүгнэлтэд хүрнэ. Тухайлбал тэр бээр Далан Балжутын тулалдаанд Жамухад ялагддаг. Мөн тэнд, р. 54-ийг үзнэ үү. Түүний хийсэн цорын ганц онцгой чухал ялалт бол татаруудыг дарсан явдал байв. Мөн тэнд, pp. 71-72-ыг үзнэ үү. Тэр бээр Жүрхэний тэргүүдийг цаазалж, Тайчуудыг дарсан нь үнэн. Мөн тэнд, pp. 58-59-ийг үзнэ үү. Гэхдээ үнэн хэрэгтээ Жүрхэний тэргүүд халз тулалдаагүй бол Тайчууд Он ханд ялагдаад ухарч явахдаа Чингист довтлуулсан. Тэгээд ч Жүрхэн, Тайчуудын аль аль нь багахан төдий хүч байсан.

⁹⁴ de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 94-95-ыг үзнэ үү.

⁹⁵ Хэрэйд, Найман, Татарын хаад *buyuruq* цолтой байв. Мэргид, Ойрадынх *beki* цолтой байв. Харин бусад нь *bahadur* юм уу, *tekin* цолтой, харин Чингис өөрөө *ja’ut quri* цолтой байсан билээ. de Rachewiltz, *Index to the Secret History*, Rashiduddin Fazlullah, *Compendium of Chronicles*-ийг үзнэ үү. Эдгээр цол цөм цэргийн юм уу, цэргийн холбогдолтой цол байсан бөгөөд хожим нь гэсэн аль нь ч хаан, удирдагчийн цолоор хэрэглэгдээгүй.

байдлаар хуваагдан оршиж байсны учрыг илтгэн харуулж байна. Харин Чингис ханы мандан бадрах цаг үед эдгээр тархай бутархай нэгж янз бүрийн хэмжээтэй улс, хан хөвүүдийн эзэмшил юм уу, ноёдын улс болсон байжээ гэж хэлж болно.⁹⁶ Тэдгээрийн зарим нь, тухайлбал *senggüm*-ийн хүү, *lingqu*-ын ач хүү Амбагай хан цолонд хүрсэн нь мэдээж хэрэг. Сузан Рейнольдс судлаачийн дундад зууны үеийн Европын жишээн дээр ажигласанчлан нэгэн үеийн засаг захиргааны нэгж дараа үедээ язгууртнуудын эзэмшил болж хувирч байжээ.⁹⁷ Гэхдээ Чингис ханыг бүрэн гүйцэлдүүлэхээс бүр өмнө тэдгээр язгууртан нэгэн улс орныг бүтээн байгуулна хэмээн ухаарч ойлгож байсан тул чухамдаа хан цолыг хүртвээс л тэр хүсэл зоригоо биелүүлж тэрхүү тусгаар улс орныг байгууллаа хэмээн үзэж байсан нь гарцаагүй.

Тийм ч учраас Хэрэйдийн Он ханы ноёрхолд эзэмшил нутгуудад хуваагдаж тархай бутархай оршиж байсан Чингисийн угсааны улс байгуулагдахаас өмнөх Монголыг доройтон буурсан Умард Юань улсын зүй ёсны хаан болох “Цахарын” Лигдан ханы ноёрхолд олон жижиг хан хөвүүдийн эзэмшилд хуваагдаж тархай бутархай оршиж байсан Чин гүрний өмнөх Монголтой жишиж болохоор санагдана. Нэг ёсондоо Чингисийн угсааны улсын зэрэг дэв бүхий аравтын нэгжүүд Чин гүрний өмнөх цаг үед харьцангуй бие даасан хан хөвүүдийн эзэмшил болон хувирах үйл явц явагдсан гэвэл Хятан улсын “синтетик буюу холимог аймгууд” нь Чингисийн өмнөх цаг үед Хэрэйдийн бүрэлдэхүүнд орохгүйгээр бие даасан байдал олж авахын тулд өрсөлдөн тэмцэлдэж байсан гэж үзэж болох юм.

Чин гүрэн болон Чингисийн угсааны улс бүрэлдэн тогтох үйл явц, мөн Чингийн өмнөх болон Чингисийн өмнөх Монголыг харьцуулан судалснаар “аймаг” буюу “язгууртны өрх, эзэмшил”-үүд нь үнэн хэрэгтээ дээрээс доош захирах цэргийн зохион байгуулалтын нэгжийг үүсгэсэн эзэнт гүрний байгууллаас тогтон буй болдог болохыг баталж болно. Харин эзэнт гүрний төвүүд нуран унахтай зэрэгцээд тэрхүү нэгжүүд өөр өөрсдийн хэв маягаар бие даасан олон жижиг улс төрийн нэгж болж эхэлдэг ажээ. Гэхдээ эзэнт гүрний бүрэлдэхүүнд нэгдэх дараагийн үйл явцад тэдгээр нэгж “дүр эсгэсэн улс төрийн” шинжтэй болон хувирахын зэрэгцээгээр хүн ам нь таран бутарч, тэрхүү эзлэн авсан эзэнт гүрнээс шинээр тогтоосон олон жижиг засаг захиргааны нэгжид хуваагдан шингэж байжээ. Тэгэхээр Дотоод Азийн бүх эзэнт гүрэн Евразийн нүүдэлчин хүн ардыг нэгтгэх, засаглахдаа хэрэгжүүлж байсан тэрхүү үе залгамжлан захирах тогтолцооны уг мөн чанарыг шинжлэн судлах нь хамгаас чухал юм.

⁹⁶ Ноёдын улсын тухайд Т. Bisson, *The Crisis of the Twelfth Century: Power, Lordship, and the Origins of European Government*, (Princeton and Oxford, 2009)-ыг үзнэ үү. Чингисийн өмнөх улс төрийн нэгдлүүдийн тухай Рашид ал-Дины бичсэн зүйлсийг Rashiduddin Fazlullah, *Compendium of Chronicles*, pp. 37-78-аас үзнэ үү.

⁹⁷ S. Reynolds, *Kingdoms and Communities in Western Europe, 900–1300*, Second Edition (Oxford, 1997), p. 221.

Үе залгамжлан захирах тогтолцоо ба Шинэ үеэс өмнөх Евразийн улс төрийн дэг журам

Эзэнт гүрэн бүрэлдэх, орон нутгийн засаг захиргаа байгуулагдах, хүн амыг бүтцийн хувьд зохион байгуулах үйл явцын мөн чанарыг судлан шинжлэх гэсэн эрдэмтэн судлаачдын сонирхолд аймгийн парадигм тодорхой хэмжээгээр саад болж байсан юм шиг санагдана. Ялангуяа нүүдэлчин хүн амыг үе залгамжлан захирч, захируулдаг засаг захиргааны нэгжид хуваан нэгтгэхийн улс төрийн ач холбогдол, түүний нөлөө, үр дагавар хангалттай судлагдаагүй юм.

Ерөнхийдөө үе залгамжлан захирах тогтолцооны⁹⁸ мөн чанарыг бичих, ялангуяа “аймгууд”-ын буюу “язгууртны дэг журам”-уудын үүсэл гарлыг сурвалжлахын тулд үе залгамжлан захирах тогтолцооны хамгийн тод томруун хэлбэр болсон Чингисийн угсааны улсын *мянгадаар* (*mingan*) зохион байгуулагдсан аравтын тогтолцооны тухай товч өгүүлэе. *Мянган* нь Монголын цэргийн тогтолцоотой холбоотой агаад энэ тогтолцоо аймгийн дэг журмыг устгасан гэсэн саналыг олон эрдэмтэн дэвшүүлжээ.⁹⁹ Гэвч Снит Хүннү, Зүрчиний аравтын байгууллыг эш татаж энэ интерпретациас эрс татгалзсан юм. Аравтын систем нь Чингис ханыг мандан бадарсан цаг үеэс бүр өмнө хэдийн бэхжин тогтсон засаг захиргааны тогтолцоо байсан гэж тэр бээр үзсэн бөгөөд мөн “МНТ-д бичигдсэн үйл явц тухайн үед оршиж байсан язгууртны эзэмшлийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн төдийгүй тэдгээр нь нийтээрээ *мянганы* засаг захиргааны тогтолцоонд нэгдсэн болохыг харуулж байгаа бололтой” хэмээн бичжээ.¹⁰⁰ Иймд овгийн байгууллыг устгаж, тал нутгийн нийгмийг аравтын эгнээгээр бүхэлд нь ахин зохион байгуулсан “Чингисийн угсааныхны хувьсгал” огт болоогүй ажээ.¹⁰¹ Түүнчлэн Атвуд Дотоод Азийн түүхийг “аймгийн үзэл”-ээр судлан тайлбарлах явдлыг шүүмжилсэн билээ. Тэр бээр Монголын *мянган*, *отог*, *хошуу* нь Монголын онцлогтой орон нутгийн засаг захиргааны үндсэн нэгж болон 500 гаруй жил оршиж байсан агаад улс төр-нутаг дэвсгэрийн нэгж болохын хажуугаар “аппанаж нийтлэг”-ийн үүргийг гүйцэтгэж байсан гэсэн маш оновчтой санааг саяхнаас дэвшүүлж баримтаар сайтар нотлон бичжээ.¹⁰²

Хаан ширээнд суусныхаа дараа Чингис хан монгол улсуудыг 95 *мянганд*

⁹⁸ Аравтын, аравтын бус тоогоор хуваан захирах нэгж ба хан хөвүүдийн аппанажыг хамруулахын тулд “үе залгамжлан захирах тогтолцоо” гэсэн нэр томъёог ашиглалаа. Ийм тоогоор хуваан захирсан нэгжүүд язгууртнуудын эзэмшил болж байсан бол хан хөвүүдийн аппанажууд угсаа залгамжилсан язгууртны эзэмшил болон хувирч байжээ. Чингисийн угсааны улсын хожуу үеийн хан хөвүүдийн аппанажуудын тухайд R. D. McChesney, “The Chinggisid restoration in Central Asia: 1500–1785”, in *The Cambridge History of Inner Asia: The Chinggisid Age*, (eds.) Nicola Di Cosmo, Allen J. Frank and Peter B. Golden (Cambridge, 2009), pp. 277–302-ыг үзнэ үү.

⁹⁹ Жишээ нь, С. Hsiao, *The Military Establishment of the Yuan Dynasty* (Cambridge, MA, 1978), pp. 9–17-г үзнэ үү.

¹⁰⁰ Sneath, *The Headless State*, pp. 113–116.

¹⁰¹ Мөн тэнд, р. 113.

¹⁰² Өгүүллийн хэмжээ хязгаартай, мөн гол асуудал биш тул энд шинжилгээгээ *мянганаар* хязгаарлалаа. Гэхдээ Атвуд *мянган* төдийгүй *хошуу*, *отгийн* тухай маш дэлгэрэнгүй шинжлэн судалсан байдаг. С. Atwood, “Banner Otog, thousand: appanage communities as the basic unit of traditional Mongolian society”, *Mongolian Studies*, XXXIV (2012), pp. 1–76-г үзнэ үү.

хувааж, түс бүрд ноён (*noyan*) томилж захируулсан билээ.¹⁰³ Тэдгээр *мянган*-ыг цааш зуун (*za'un*), *арванд* (*har'ban*) хуваасан.¹⁰⁴ Мөн тэдгээр *мянганы* заримыг нь бүлэглэн *түмэнг* (*tümen*) үүсгэсэн.¹⁰⁵ Энэ нь тодорхой тогтсон тоон нэгж үүсгэж, түүнд арав аравтаар шатлан захирах үр дүнтэй удирдлагыг буй болгосон тул хүн амыг тун хялбар, үр дүнтэй, ойлгомжтой засаглах тогтолцоо байв. Энэ тогтолцоо нь дайн болоход цэргийг яаралтай татаж бэлэн болгох боломжийг олгож байсан нь тодорхой.¹⁰⁶ Мөн дээрээс доош захирах байгуулал байсны¹⁰⁷ зэрэгцээ адил хэмжээ, байр суурьтай засаг захиргааны нэгж үүсгэж *ноёдын* эрх мэдэл хүсээгүй байдлаар тэлэхээс сэргийлж байсан тул хааны гарт эрх мэдлийг төвлөрүүлэх зорилготой буй болгосон тогтолцоо болж байсан нь гарцаагүй. Иймд энэ нь хүн амыг цэрэгт дайчлан хөдөлгөх, эрх мэдлийг хааны гарт төвлөрүүлэх үр дүнтэй, хялбар тогтолцоо байжээ.¹⁰⁸ Эцэст нь, энэ нь өмнө нь оршиж байсан улс төрийн том нэгдлүүдийг задалж бутаргах замаар нэгтгэхэд уян хаган тогтолцоо байжээ. Тэр бүү хэл тайван замаар дагаар орсон Онгуд, Урууд, Хонгирад, Баарин, Ихэрэс аль алиныг *мянгадад* хуваасан юм.¹⁰⁹

Мянган нь Чингисийн засаг захиргааны тогтолцооны ноён нуруу байсан бөгөөд орон нутгийн засаглалын хамгийн чухал нэгж болж байжээ. Тэгэхээр орон нутаг бүр аравт аравтаар шат дараалан нэгэн жигд зохион байгуулагдсан засаглалын хэлбэртэй байхын зэрэгцээ *nuntu'usin* гэх төрөөс тусгайлан томилсон

¹⁰³ Чингис хан 45 орчим мянган иргэнийг (*irge*) эх, дүү, хөвүүддээ хуваарилж өгсөн бөгөөд дор хаяж 17 мянганы ноёныг томилж тэдэнд зүтгүүлсэн гэж бичсэн байдаг. de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 138-139, Hsiao, *The Military Establishment*, pp. 9-17-г үзнэ үү. Чингис хан аравтын тогтолцооноос гадна хан хөвүүдийн аппанажыг байгуулсан юм.

¹⁰⁴ de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 114. Мөн Atwood, “Banner Otog, thousand”, pp. 26-27-г үзнэ үү. Эзэнт гүрэн тэлэхэд олон хүмүүс энэ тогтолцоонд хамрагдаж *мянган*, *түмний* тоо хэмжээ нэмэгдсээр байжээ. Тухайлбал, Чингис ханд 126 мянган байсан гэж Рашид ал-Дин бичсэн байхад Өгэдэй ханд найман түмэн байсан гэж нанхиад элч Пэн Даяа мэдээлжээ. Rashiduddin Fazlullah, *Compendium of Chronicles*, pp. 273-281, Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 139, Hsiao, *The Military Establishment*, pp. 9-17-г үзнэ үү. Байлдан дагууллынхаа явцад Чингисийг залгамжлагчид *мянган*, *түмэнг* тогтмол өөрчлөн байгуулж байв. Өөрчлөн байгуулах үйл явц байлдан дагууллын дараах үеүдэд ч үргэлжилсэн. Тухайлбал, Кебер (1318-1326) Цагадайн улсын *түмэнг* өөрчлөн ахин зохион байгуулж байжээ. В. Manz, *The Rise and Rule of Tamerlane* (Cambridge, 1989), pp. 9, 24-ийг үзнэ үү.

¹⁰⁵ Atwood, “Banner Otog, thousand”, pp. 27-28. *МНТ*-д “баруун гарын Алтай дэрлэхүүний түмэн”, “зүүн гарын Харагун Жидунийг дэрлэхүүний түмэн”, “төвийн түмэн”, “гүм дүүрч... Эрдис Худус” хэмээн өгүүлснийг үзвэл эхэндээ түмтийн тогтолцоо нь нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын нэгж байсан мэт санагдана. de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 117-118, 127.

¹⁰⁶ Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 139.

¹⁰⁷ Чингис хан өөрөө *түмэн хэшигтэн* (*tümen kesikten*) илүү том хүчтэй байсныг дурдах нь хэрэгтэй. Үүнд *мянгат*, *зуут*, *аравтын ноёдын* хөвүүд багтаж байв. *Хэшигтэн* нь “гаднадус мянгад”-аас (*qadanadus minqad*) дээш байр суурьтай байв. de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 127-133-г үзнэ үү.

¹⁰⁸ Нүүдэлчдийн нийгэм дэх цэргийн зохион байгуулалтын тухайд N. di Cosmo, *Ancient China and Its Enemies: The Rise of Nomadic Power in East Asian History* (Cambridge, 2004), pp. 181-183-ыг үзнэ үү.

¹⁰⁹ de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 114.

түшмэдээр захируулсан *nuntuq* хэмээгдэх газар нутагтай байв.¹¹⁰ Аравт бүрд ноёдыг төрөөс, мянган бүрд ноёдыг хаан томилдог байсан тул хуулийн хувьд ноёд бүр тэгш байр суурьтай байжээ.¹¹¹ Мөн *мянган* бүр цэрэг дайны албаас гадна татвар цуглуулах, хааны албанд биеийн алба өгч зүтгэх үүрэгтэй байсан. *МНТ*-д “зүг зүгийн мянгад мянгадаас” гүү гаргаж саагаад, хоол шүүсэнд хонь өгч, өргөөний унаач гаргах зарлиг буулгаж байдаг.¹¹² Иймд *мянган* нь засаглалын нэгж ч, орон нутгийн засаг захиргааны нэгж ч мөн байв.

Гэхдээ *мянган* нь зөвхөн түшмэдийн хүнд суртал бүхий засаг захиргааны нэгж бус, харин өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй байгууламж болох нэг онцлог шинжтэй байжээ. Тэр нь мянгадын цэрэг нь үе залгамжлан захирагддаг¹¹³, харин ноён нь угсаа залгамжлан захирдаг¹¹⁴ явдал юм. Үе залгамжлан захирах, захирагдах ёс *мянганыг* ийм онцлогтой болгоод зогсохгүй улс бүрэлдэхэд нөлөөлж байв. Үнэндээ үе залгамжлан захирах, захирагдах ёс *мянганыг* Атвудын оноосноор хоёр талын шинж чанартай болгодог байна: нэгт, “ямар нэг

¹¹⁰ de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 171. Тус албыг Өгэдэй ханы (1229-1241) үед бий болгожээ. Мянгадад нутаг ус хувааж өгч захируулах нь том үйл хэрэг байв. Нутгийн маргаанаас үүдэн байнгын тэмцэл өрнөдөг байжээ. Atwood, “Banner Otog, thousand”, pp. 28-30-ыг үзнэ үү.

¹¹¹ de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 99-100, 114-120, 131, Hsiao, *The Military Establishment*, pp. 9-73.

¹¹² de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 171-172.

¹¹³ “Арван таваас далан насны хоорондох бүх эрчүүд”-ийг бүртгээд *yasa* хуулийн дагуу “нэг ч эрийг томилогдсон зуут, мянгад, аравтаас өөр нэгжид явуулдаггүй, орогнуулдаггүй. Энэ журмыг зөрчвөөс тэрхүү шилжсэн этгээдийг цэргүүдийн өмнө хороох бөгөөд түүнийг шилжүүлж авсан хүнийг ч бас хатуу шийтгэнэ”. Ala-ad-Din ‘Ata-Malik Juvaini, *The Genghis Khan: The History of the World-Conqueror*, translated by J. Boyle, (Manchester, 1997), p. 32-ыг үзнэ үү. Цэргийн үе залгамжлан албанд зүтгэдэг тухайд Hsiao, *The Military Establishment*-ыг үзнэ үү. Эдгээр хориг хууль *мянгадын* цэргүүдийг үе залгамжлан алба хаших нөхцөлийг бүрдүүлж байжээ. Аравтын нэгжүүдийг “Хөх дэвтэр”-г бүртгэх нь эхэн үед хэрэгжүүлж байсан ёс болно. de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 115-116-г үзнэ үү. Гэхдээ анх томилогдсон нэгжийг орхихыг хориглосон хуулийг харьяат иргэдийн дунд хожим маргаан гарах, ноёдын гарт эрх мэдэл, хөрөнгө мөнгө төвлөрөхөөс сэргийлж гаргасан байж болох юм. Гэвч хүчирхэг Хөхөчү Тэв Тэнгэр бөө, Чингис хааны отгон дүү Тэмүгэ отчигинтой холбогдсон харьяат иргэдийн талаарх маргаанаас үүдсэн нэг хэрэг гарсан байдаг. Тэмүгэгийн зарим харьяат эзнээ орхин Тэв Тэнгэрт одсонд Тэв тэнгэр тэднийг буцаахаас татгалзжээ. *МНТ*-д Чингис ханыг байсан ч Тэв Тэнгэр эрх мэдэл, нөлөө хуримтлуулсан тухай бичсэн бөгөөд энэ хэрүүл явсаар Тэв Тэнгэрийг хорооход хүргэсэн билээ. Мөн тэнд, pp. 139-144.

¹¹⁴ Үе залгамжлан захирах эрхийг олгоно гэдэг нь ноёдыг хаанд үнэнчээр зүтгүүлэх гол арга хэрэгсэл байв. Atwood, “Banner Otog, thousand”, pp. 35-36-г үзнэ үү. Эрх мэдэл маш хүчтэй төвлөрсөн Юань улсын үед ч албууд үе улиран залгамжлагддаг байв. Hsiao, *The Military Establishment*, pp. 9-32-ыг үзнэ үү. Тиймээс *Юань улсын судар*-г “Хэрвээ *wan-hu* (түмний цэрэг) юм уу, *ch’ien-hu* (мянганы цэрэг) тулалдаанд үргэдвэл үр хойчсын аль нэг цолыг залгамжилна. Өвчнөөр нөгчвөөс [залгамжилсан цолыг] нэгэн зэргээр бууруулмуй... Хожим нь өндөр, буурайг үл ялгаварлан бүх албыг улируулна. Хэрэг ослоор хасагдсаныг гагц чингэхгүй” хэмээн мэдээлжээ. Hsiao, *The Military Establishment*, p. 73-ыг үзнэ үү. Мэдээж хэрэг Их хаад бутран задрах аюул буйг ухаарч байв. Тиймээс тухайлбал, Мөнх хаан үнэнч зүтгэж байгаа эсэх нь эргэлзээтэй ноёдыг олноор нь хороож байв. Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, p. 363-ыг үзнэ үү. Юань улсын хаад иргэний бүх алба, хятад цэргийн бүх жанждыг үе улируулан залгамжлуулдаггүй болгосон. Гэвч Монгол ноёдын үе залгамжлан захирах эрхийг хөндөлгүй үлдээжээ. Hsiao, *The Military Establishment*, pp. 25-26-г үзнэ үү.

язгууртан, түүний үр удамд үе залгамжлах ёсны дагуу орон нутгийн засаглалын нэгж болж оногдсон тодорхой нэг газар нутаг, хүмүүс” буюу аппанаж, хоёрт, “аппанажийн нөөц баялгийг тодорхойгүй хугацаанд эзэмших, өмчлөх эрх хадгалж, тэдгээр эрх ямбыг зөвхөн доторх гишүүдээр хязгаарлаж олгодог, гадны хүмүүстэй идэвхтэй харилцаа тогтоохоос түдгэлздэг бүлэг хүмүүс буюу хаалттай хамтарсан нийтлэг”.¹¹⁵ Хэрвээ үе залгамжлан захирах ёс *мянгадыг* хооронд нь салгадаг байсан бол үе залгамжлан захирагддаг ёс нь тэдгээрийг тусгаарладаг байв. Чухамдаа уг тогтолцоог бүхэлд нь авч үзвэл тусгаар *мянгадыг* хооронд нь хэрж холбосон маш сул хэвтээ нэгдэл байсан аж. Ийм учраас эзэнт гүрнийг хүч чадалтай байх цагт уг тогтолцоо нь өөрийн гэсэн эрх баригч угсаанд захирагддаг өөр хоорондоо салангид орших хүн амын бүлэг буюу орон нутгийн нийтлэгүүдийг бий болгож байв.¹¹⁶ Гэтэл бодит байдал дээрээ эзэнт гүрэн нөмөр нөөлөг дор олон тооны язгууртны эзэмшил буй болох боломж нуугдаж байжээ. Улсын болон орон нутгийн хэмжээний хан хөвүүдийн эрх мэдэл тарамдахад *мянган*, *түмэн* өөрсдөдөө эрх мэдэл хурааж тусгаар тогтнох хандлагатай байв.¹¹⁷

Үүний хажуугаар үе залгамжлан захирах, захирагдах ёсны үр дүнд *мянгад*, *түмтэд* оногдсон хүн ам өөрийн гэсэн өвөрмөц айн буюу бүлгийн адилслыг хөгжүүлж, хадгалж байжээ. Тэдний ихэнх нь *ноёдын* нэр юм уу, *ноёдын* сонгож, салбарлуулсан нэрээр нэрлэгдэн адилсаж байв. Өөрөөр хэлбэл, тэдгээр нэр мянгадын хүн амын нэр болж байжээ. Мөн Атвудын оновчтой ажигласнаар чухам энэ шалтгаанаар эзэнт гүрний дараах үед маш олон угсаатны нэр тохиолдож байна.¹¹⁸ Тэдний адилслыг бүрдүүлэгч *мифмотор* нь эрх барьж буй язгууртны өрх гэрт төвлөрч байсан нь тодорхой.¹¹⁹ Ноёны алба үе улиран залгамжлагдах, өвлөгдөх нь чухал утга учиртай байсан тул эрх барьж буй тэрхүү язгууртны өрх

¹¹⁵ Атвуд *мянган*, *отог*, *хошууг* “эзэмшил (fief) буюу аппанаж” хэмээгээд “Монгол зэрэг олон улсад язгууртнуудаас оноосон хувь газар, хүмүүс” гэж тодорхойлсон хэмээн тэмдэглэжээ. Atwood, “Banner Ogot, thousand”, pp. 2, 29-ийг үзнэ үү. *Мянган*, *отог*, *хошуунд* адил төстэй тал бий ч аль нь ч хувь биш, харин эзэмшлийг (fief) өмчийн нэгж болгон өгсөн орон нутгийн засаг захиргааны нэгж юм. S. Reynolds, *Fiefs and Vassals: The Medieval Evidence Reinterpreted* (Oxford, 1994), p. 48. Нөгөө талаар, Чингис хан *хувийг* эх, хөвүүд, дүү нартаа өгсөн. Үнэн хэрэгтээ эдгээрийг аппанаж гэж үзэж болно. de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 138-139-ийг үзнэ үү. Хэдийгээр ялгаатай ч гэсэн үе улируулан захирдаг байсан Их Карлын угсааны улсын контууд орон нутгийг засаглах нэгж болж байсан байдлаар нь *мянгантай* нэлээд ойр утгатай байсан байх боломжтой. Reynolds, *Fiefs and Vassals*-ыг үзнэ үү.

¹¹⁶ Зүчи, Цагадай, Өгэдэй, хожим нь Хүлэгүгийн эзэмшил нь тэдний өөрсдийнх нь л эзэмшлийг агуулж байсан нь үнэн. Гэхдээ эрх мэдлийн эдгээр төв хааны хүч чадлыг танаж, эзэнт гүрний бутралыг хурдасгаж байжээ. Үнэн хэрэгтээ эзэнт гүрний эрх баригч элитүүд энэ хандлагыг маш сайн ухаарч байсан тул бутралыг зогсоохын тулд олон арга хэрэглэхийг оролдож байв. Тэдгээр аргад хилийн чанадыг хянан суух төлөөлөгч томилох, цэрэг армийг сэлгэн зохион байгуулах, эзэнт гүрэн даяар хан хөвүүдийн хувийг хооронд нь хольж нийлүүлэх гэх мэт багтаж байв. Тухайлбал Hsiao, *The Military Establishment*-ыг үзнэ үү.

¹¹⁷ P. Jackson, “From Ulus to Khanate: the making of the Mongol states c. 1220-c. 1290” in *Mongol Empire and Its Legacy*, (eds.) Reuven Amitai-Preiss and David Morgan (Leiden, 1999), pp. 12-38.

¹¹⁸ Atwood, “Banner Ogot, thousand”, p. 28.

¹¹⁹ *Мифмотор* гэх ухагдахууны тухайд A. D. Smith, *The Ethnic Origins of Nations* (Oxford, 1986)-г үзнэ үү.

гэрийн угсаа залгамжийг нэн сайн бүртгэн санаж байх ёстой болж байсан ба цаг хугацааны явцад маш олон тохиолдолд ноёдын эрх барьж буй өрх гэрийн хүндэт өвөг дээдэс юм уу, үндэслэгчид нь тэдгээр мянганы хүн амын угсаатныг бүхэлд нь нэрлэх өвөг дээдэс болох хандлагатай байжээ. Жишээ нь, *Юань улсын судар*-ын Жүрчидэйн намтарт Жалайр, Урууд, Мангуд, Хонгирад, Ихэрэс мянганы алдарт ноён Жүрчидэйн өвөг дээдэс болох Начин Баатараас гаралтай гэжээ.¹²⁰ Гэтэл Начин Баатарыг Урууд, Мангудын өвөг дээдэс гэж МНТ-д өгүүлсэн байдаг.¹²¹ Үе залгамжлан захирах тогтолцоо нь тухайн захирагдаж буй хүн амд угсаа залгамжлан захирах эзэн ноёдын өрх гэрт үнэнчээр зүтгэхээс өөр аргагүй нөхцөл байдлыг үүсгэдэг байсан бол эзэн ноёны өрх гэрийн угсаа гарвалыг үүтгэж буй мифмотор нь харьяат хүн амыг бүхэлд нь хамарч, тэднийг тэрхүү эзэн ноёны өрх гэрийн домгуудаар нэгтгэж байсан гэж хэлж болно. Иймд үе залгамжлах тогтолцоо нь нэгжийн хүн амыг хамтарсан нэг нийтлэгт нэгтгэхийн сацуу гарал үүслийн нийтлэг домгоор холбогдсон өвөрмөц, удаан хугацаанд үргэлжлэх адилсал бүхий бүлэг болгон хувиргадаг байна. Эцэст нь, эзэнт гүрэн, орон нутгийн шинжтэй хант улсууд сүйрч мөхөхөд тэдгээр нэгж харьцангуй бие даасан *мянган-улс* юм уу, *түмэн-улс* болон гарч ирсэн ба мөн бусдаас ялгагдах адилсалтай бүлэг болсон байжээ.

Энэ үйл явц XIV, XV зуунд Монголын эзэнт гүрэн даяар явагдсан нь тодорхой мэдэгдэж байна. Олон *түмэн*, *мянган* нь ноёдын харьцангуй бие даасан эзэмшил болон хувирсан байдаг. Энэ нь бүтцийн хувьд эзэнт гүрэн даяар адил төстэй явагдсан ба үр дүнд нь улс төрийн тарж бутарсан, сарнисан дэг журам – Снитийн тодорхойлсноор язгууртны дэг журам, эсвэл эрдэмтэн судлаачдын дунд хэлж тогтсоноор олон аймаг – үүссэн байна. Ингэхдээ Монголын эзэнт гүрний зүүн хагаст арав гаруй *түмэн* юм уу, *улсад*, мөн түүнээс олон тооны *отог* юм уу, *хошуунд* орших болсон бол баруун хагас нь Чингисийн угсааны орон нутгийн хант улсууд доройтон мөхөх үед олон *түмэн* юм уу, *улсад*¹²², мөн л олон *хошуун* юм уу, *хазарад* хуваагджээ. Гэхдээ тэдгээр нь эзэнт гүрний засаглалыг бүрэлдүүлэгч эд эс болж байсан тул Фридийн томьёолсон “хоёрдогч түвшний аймаг” огт байгаагүй юм. Харин ч тэдгээр нь Фридийн өөрийнх нь нэрлэснээр эмирийн улс (emirate) юм уу, жижиг эзэн ноёны улс (kingdom) болсон, гэхдээ энэ үйл явц Чингисийн угсааны орон нутгийн хант улсууд мөхсөний дараа явагдсан билээ.¹²³

Тиймээс цэргийн зохион байгуулалттай үе залгамжлан захирах тогтолцоо нь өвөрмөц адилсал бүхий ноёдын эзэмшлийг (буюу язгууртны өрх гэр, эсвэл аймаг)

¹²⁰ Atwood, “Banner Otag, thousand”, p. 32. Бодит байдал дээр эрх барьж буй ноёдын өвөг дээдэс нь түүний захирч буй нэгжийн өвөг дээдэс болж байсан тухай олонтоо бичигдсэн байдаг. Munkh-Erdene, “The Mongolian Nationality Lexicon”-ийг үзнэ үү.

¹²¹ de Rachewiltz, *Index to the Secret History*, pp. 20-21.

¹²² Тухайлбал, Цагадайн улсад Барулас, Сүлдүс, Арлат, Жалайр нь Чингисийн угсааны улсын мянган байсан бол Харгунас, Нэгүдэри, Ясагури, Апарди, Хутталани, Боролдай зэрэг нь хожуу үеийн түмэн байв. Manz, *The Rise and Rule of Tamerlane*, pp. 22-36-г үзнэ үү.

¹²³ Fried, *The Notion of Tribe*, p. 65.

үүтгэдэг гол хүчин зүйл болж байжээ.¹²⁴ Ийм эзэмшлүүд гол эрх баригч хааны төв хүч, давуу байдлыг хүлээн зөвшөөрч буй цагт илүү том улс төрийн нэгдлийн харьяат нэгж буюу орон нутгийн засаглалын нэгж болж оршиж байв. Хүн амыг цэргийн тоогоор зохион байгуулж адилсал үүсгэсэн олон нэгжид бүлэглэх, хуваах нь дайнтай цаг үед эрх мэдлийг төвлөрүүлэх, цэрэг дайчлан хөдөлгөх давуу талыг өгч байсан нь тодорхой. Гэвч уг тогтолцоог бүхэлд нь авч үзвэл хааны эрх мэдэл дор салангид тусдаа, өөрийн гэсэн адилсал бүхий олон жижиг бүлгийг дотроо үүсгэсэн нөхцөлд тэдгээр нь үе залгамжлан захирах, захирагдах ёсны дагуу ноёдын эзэмшил юм уу, эсвэл өөрийн гэсэн өвөрмөц адилсалтай саланги тусдаа олон бүлэг болон хувирч байжээ. Тэгтэл орон нутгийн эрх баригч үе залгамжлан захирч байгаа нөхцөлд хэрвээ төв засгийн газраас саад болох ямар нэг арга хэмжээ авахгүй бол орон нутгийн нэгж өөрсдөө аяндаа харьцангуй бие даасан ноёны эзэмшил болох хандлагатай байв.¹²⁵ Ялангуяа хааны төв эрх мэдэл машид суларч, *МНТ*-д тун ч онож хэлснээр, “гүр улс булха” болох үед бүр ч тод ажиглагдаж байсан нь лавтай.¹²⁶

Дүгнэлт

Эзэнт гүрнийг байгуулагчид эрх мэдлийг төвлөрүүлэх, цэрэг хөдөлгөх үр дүнтэй тогтолцоо боловсруулахыг эрмэлзэхдээ цэргийн зохион байгуулалтай үе залгамжлан захирах нэгжүүдэд хөдөлмөрийн хүчийг хуваах замаар өвөрмөц адилсалтай улс төр-газар нутгийн нийтлэгүүдийг төрийн бүтцийн дотор байгуулж байсныг бид авч үзлээ. Ингэхдээ “аймаг” буюу “язгууртнаар удирдуулж нэрлэгдсэн бүлэг”-үүдийг судалж үзэхэд тэдгээр нь “төвлөрсөн төр” буюу “эзэнт гүрний төр” хэмээн эрдэмтдийн нэрлэж буй дээрээс доош захирсан засаглалын онцлогтой байсан ажээ. Тэдгээрийг төр өөрөө засаглах, цэрэг дайчлах арга хэрэгсэл болгохын тулд бүтээж байв. Энэ талаас нь авч үзвэл тэдгээр нь эзэнт гүрний бүтцийн дотор багтаж байсан ч төрийн урьдач, ямар нэг бодитой юм уу, домгийн гаралтай ураг төрөлд суурилсан бүлэг болж оршиж байжээ. Албанд зүтгэж, гавьяа байгуулсных нь шагнал, баталгаа болгож эзэнт гүрний төрөөс захирагч, жанждад хүртээдэг байсан засаг захиргааны үе улиран залгамжилдаг ийм албаас Снитийн томьёолж буй язгууртны засаглал гэгч үүсэн хөгждөг гэсэн нь миний авч үзсэн зүйлтэй төстэй юм.

Гэхдээ үе залгамжлан захирдаг тэдгээр захирагч жанжин хааны төв хүч доройтон сулрах цагт хаан ширээний төлөө өрсөлдөн тэмцэлдэгч бие даасан язгууртан ноёд болж гарч ирдэг бөгөөд өөртөө харьцангуй бие даасан эзэмшил үүсгээд, түүнийгээ эрх мэдлийн суурь дэвсгэрээ болгодог ажээ. Ингэхдээ захирагч жанжин нь эзэн хааны засаг захиргааны нэгжид хамаарч, эзэн хаанаас хүртсэн үе залгамжлан захирах эрх бүхий алба нь холбоо харилцаагаа багатган

¹²⁴ Дундад зууны үеийн Европын нөхцөл ч өөр байгаагүй гэдгийг бас тэмдэглэх нь зүйтэй. Reynolds, *Kingdoms and Communities*, Bisson, *The Crisis of the Twelfth Century*-ыг үзнэ үү.

¹²⁵ Reynolds, *Kingdoms and Communities*, Bisson, *The Crisis of the Twelfth Century*-ыг үзнэ үү.

¹²⁶ de Rachewiltz, *Index to the Secret History*, p. 150.

зузааруулах арга хэрэгслийн үүрэг гүйцэтгэж байв. Монгол, Манж гүрнийг үндэслэн байгуулагчид ийм энгийн байр сууринаас дэвшиж, хаан ширээний төлөө өрсөлдөн тэмцэж, төр улсаа зүй ёсоор хүлээн зөвшөөрүүлсэн юм. Ингэхдээ үндэслэн байгуулагч хаадын аль аль нь өмнө оршиж байсан улс төрийн нэгдлүүдийг *мянган*, *хошуу* зэрэг цэргийн тоогоор зохион байгуулсан нэгжүүдэд бутарган хуваах замаар улсдаа нэгтгэсэн ажээ. *Мянган*, *хошуу* аль аль нь үнэнч зүтгэж, харьяат болж буй хүмүүсийг *ноён*, *засгийн* хувиар үе улиран захирдаг байгуулал болно. Тиймээс төр юм уу, эзэнт гүрэн байгуулах явцад үе залгамжлан захирах нэгж үүсэж засаг захиргааны хэлбэр, мөн “дүр эсгэсэн улс төрийн” хүн ам болж хувирч байв. Иймд үе залгамжлан захирах тогтолцоо нь аажимдаа өвөрмөц адилсал бүхий ноёдын олон эзэмшлийг үүтгэдэг гол хүчин зүйл болж байжээ. Нэг ёсондоо, эзэнт гүрнийг бүрэлдүүлэх бодлогоос язгууртны засаглал, “аймгууд” үүсэн бий болж байсан ажээ.

Орчуулсан Б.Чинзориг